

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-7

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 8-41

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	8-34
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай/	34-39
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай/	39-41

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 22-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Б.Бат-Эрдэнэ, П.Сайнзориг;

Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Ц.Сандаг-Очир.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, мэргэжилтэн П.Энхманлай, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дашням, Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, мэргэжилтэн Э.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, ахлах шинжээч Г.Базаргүр, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн Ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Ц.Ням-Очир, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Н.Алтансүх, Мөрдөн байцаах албаны дарга П.Очбадрах, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Х.Лхагвасүрэн, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Өнөртуяа, Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Энх-Од, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Ж.Буянбат, мөн газрын Санхүү, хангамжийн газрын ерөнхий нягтлан бодогч Т.Батцэцэг, Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Ж.Солонго, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Э.Чулуунцэцэг, Дотоод хэргийн их

сургуулийн захирал П.Батбаатар, мөн сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Лхагважав, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Х.Бат-Ирээдүй, мөн эмнэлгийн Санхүү, хангамжийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунтөгс, Хууль зүйн туслалцааны төвийн захирал Л.Уянга, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, ахлах аудитор Ш.Наран, аудитор Ж.Мөнхбилгүүн, Г.Оюунтөгөлдөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны ахлах мэргэжилтэн Б.Галсанбат, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ц.Отгонбаатар нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, С.Эрдэнэболд, Г.Уянгахишиг, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга П.Очбадрах, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр, Д.Ганбат, Х.Баасанжаргал, Дав.Цогтбаатар, М.Нарантуяа-Нара, Х.Тэмүүжин, О.Номинчимэг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дам.Цогтбаатарын гаргасан, 1.Төслийн 2 дугаар хавсралтад Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн байрууд /улсын хэмжээнд/, төсөвт өртөг 61,600.0 сая төгрөг, санхүүжих дүн 61,600.0 сая төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, төсөвт өртөг 10,383.7 сая төгрөг, санхүүжих дүн 10,383.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг тус тус нэмэх. Нийт 71.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг доор дурдсан төсөл, арга хэмжээний дүнг бууруулах замаар гаргах. Үүнд:

1. 4.1.4.1-д тусгагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /бүсүүдэд/, төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 40 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах;

2. 10.2.1.2 дахь заалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах /бүсүүдэд/, төсөвт өртөг 11 тэрбум төгрөг, 2025 онд санхүүжих дүн 11 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах;

3. 10.1.3.2 дахь заалтын Гаалийн хяналтын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, төсөвт өртөг 12.9 тэрбум төгрөг, 2025 онд санхүүжих дүн 12.9 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах;

4. 10.3.3.1 дэх заалтын Татварын байгууллагуудын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, төсөвт өртөг 8 тэрбум төгрөг, 2025 онд санхүүжих дүн 8 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Дам.Цогтбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Дам.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 24.1.1 дэх хэсгийн Улсын дээд шүүхийн цахим систем /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, төсөл, арга хэмжээнд тусгагдсан 2,493.0 сая төгрөгийн зардлаас 1,919.0 сая төгрөгийг хасаж, 24.3.1 дэх хэсгийн Улсын дээд шүүхийн тоног төхөөрөмж 2,942.0 сая төгрөг /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ төсөл, арга хэмжээний зардал дээр нэмж, 4,850.0 сая төгрөг болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Дам.Цогтбаатар, Д.Ганбат, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатарын тавьсан асуултад Хүний эрхийн дэд хорооны даргад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Дам.Цогтбаатар, Б.Энхбаяр, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Хүний эрхийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболдыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолыг уншиж, танилцуулав.

Уг асуудлыг 13 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дэд дарга О.Бат-Эрдэнийг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Хүний эрх, эрх зүйн бодлогын зөвлөх Х.Номингэрэлийг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболдыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэгийг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын саналыг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэв.

6.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондовыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Монголын хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн Ц.Мөнхбатыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Монголын өмгөөлөгчдийн холбооны Зөвлөлийн гишүүн З.Сүхбаатарыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрахыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Б.Амарсанааг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнээр Отгонтэнгэр их сургуулийн ахлах багш С.Эрдэнэболорыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны дарга “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 10 минут үргэлжилж, 22 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим,
11 цаг 25 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

2025 оны, өнөөдөр юу хэлэлцэх асуудал 3 асуудал байж байгаа. Тэгэхээр хэлэлцэх асуудлынхаа, эхлээд хэлэлцэх асуудлаа баталъя.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдааны ирц 54,5 хувьтай байна. Д.Цогтбаатар гишүүн, Алтанхуяг гишүүн, Баасанжаргал гишүүн, Нарантуяа-Нара гишүүн, Номинчимэг гишүүн, Одонтуяа гишүүн, Пүрэвдорж гишүүн, Отгонбаяр гишүүн, Тэмүүжин гишүүн, Уянгахшиг гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Энхбаяр гишүүн, Эрдэнэболд гишүүн гэсэн ийм ирцтэйгээр 54,5 хувийн ирцтэйгээр хурал эхэлж байна.

Ингээд Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл. 1 дүгээр асуудал байна.

2 дугаар асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл. Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай асуудал байж байгаа.

3 дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл. ШЕЗ-ийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Саналаа өгье. Алга байна. Хэлэлцэх асуудлыг баталлаа. Энэ 3 асуудлаар ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлъе.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Би түрүүн бас гишүүддээ хэлсэн. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн бол маш их байгаа тул би юугаар нь танилцуулаад явчихъя, байгууллагуудаар нь танилцуулаад явчихъя. Архивд бол энд оролцож байгаа гишүүдийн нэрс нь та нарт тараасан байгаа материалд гишүүдийн ажлын хэсэгт байгаа гишүүдийн нэрс байж байгаа. Мөн түүнчлэн архивд энэ хүмүүсийн нэрс нь энэ хуралдаанд оролцсон гээд орно.

ХЗДХЯ-ны төлөөлөгчид байж байна. ХЭҮК-ын төлөөлөгчид байж

байна. Улсын дээд шүүхийн төлөөлөгчид байгаа, төлөөлөл. ШЕЗ-ийн төлөөлөл орсон байгаа. Шүүхийн сахилгын хорооны төлөөлөл байна. АТГ-ын төлөөлөл байж байгаа. УЕПГ-ын төлөөлөл байна. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын төлөөлөл байж байна. ЦЕГ-ын төлөөлөл байна. ХХЕГ-ын төлөөлөл байна. ШШГЕГ-ын төлөөлөл байна. УБЕГ-ын төлөөлөл байна. Шүүх шинжилгээний ерөнхий газрын төлөөлөл байна. ГИХГ-ын төлөөлөл байгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн төлөөлөл байна. Архивын ерөнхий газрын төлөөлөл байна. Мэдээлэл шуурхай удирдлагын төлөөлөл байна. Дотоод хэргийн их сургуулийн төлөөлөл байна. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төлөөлөл байна. Хууль зүйн туслалцааны төвийн төлөөлөл байна.

Ингээд Сангийн яамнаас бас төлөөлөл байж байгаа. Татварын газраас төлөөлөл байна. Мөн түүнчлэн ингээд Сангийн яамны төлөөллүүд бол энд маш өргөн бүрэлдэхүүнтэй ирсэн байгаа. ЗТЯ-ны төлөөлөл байж байна. Ингээд төлөөллүүдийг бол би байгууллага, байгууллагаар нь танилцуулчихлаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгье. 5 дугаар микрофон.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүдийн өглөөний мэндийг эрье ээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 25 оны төсвийн тухай хуулийн

төслийг 24 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар ийнхүү хэлэлцүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, татвар, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, авлигыг бууруулж, хүний эрх, засаглалыг сайжруулах зэрэг эрх зүйн 14 реформ, эдийн засгийн суурийг тэлж, хөгжлийг эрчимжүүлэхийн тулд 14 мега төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Ирэх 2025 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас ирэх оны төсвийг бүсчилсэн хөгжилд шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, орон нутаг бие даан хөгжихөд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс онцлогтой юм.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаарх илтгэлд баривчлах болон хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах үүднээс албан хаагчдын оролцоо, хүртээмжийг сайжруулах шаардлагатайг дурдаж, эрүүдэн шүүхээс сэргийлэхийн тулд албан хаагчдын ажлын ачааллыг зохицуулах нь чухал гэж тэмдэглэсэн байдаг.

Нийтийн хэв журмыг хангах, цагдаагийн байгууллагын ачааллаас шалтгаалж эрх ашгаа хамгаалуулж чадахгүй хохирч байгаа иргэдийн эрхийг хамгаалах, хүний эрхийг хамгаалах, ажиллагаанд олон нийтийг оролцуулах, иргэдийн аюулгүй орчинд амьдрах, цахим халдлагаас ангид байх эрхийг баталгаажуулах чиглэлээр нэмэлт арга

хэмжээ авах шаардлагатай байгааг харгалзан Хууль зүй дотоод хэргийн салбарт эрх зүйн шинэтгэл хийх арга хэмжээний зардлыг төсвийн төсөлд тусгалаа.

Ингэснээр хүний эрхийн олон улсын механизмууд болон Монгол Улсын ХЭҮК-ын зөвлөмжүүдийг Засгийн газар хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг тогтмол авдаг байх чухал ач холбогдолтой.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 онд төсвийн бодлого хэрэгжсэнээр нэгдсэн төсвийн нийт орлогын хэмжээ 36,8 их наяд, төсвийн нийт зардал 35,8 их наяд гэсэн төсвийн суурь, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,9 их наяд төгрөгийн ашигтай байхаар төлөвлөлөө.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 25 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 25 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 25 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Танилцуулаад дуусчихсан байгаа юу. Болдын Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Загджав даргын микрофоныг өгье. 4 дүгээр микрофон.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын

байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж үнэлэхэд чиглэсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шат болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 33 их наяд 864,7 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35,6 хувь, нийт зарлага 35 их наяд 795,2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37,7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909,5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 930,5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ.

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд:
1 их наяд 815,1 тэрбум, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч 32,9 тэрбум, ШЕЗ-ийн дарга 319,7 тэрбум, Шүүхийн сахилгын хорооны дарга 6,4 тэрбум, УЕП 145,7 тэрбум, ХЭҮК-ын дарга 15,6 тэрбум, АТГ-ын дарга 58,2 тэрбум, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга 8,3 тэрбум.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн эрхлэн захирагчдын 2025 оны төсвийн төслийг 2024 оны туссан төсөлтэй харьцуулахад ХЗДХ-ийн сайдын багцын УБЕГ-ын орлогыг 0,7 тэрбум төгрөгөөр, Шүүхийн ерөнхий газрын орлогыг шүүгч Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын орлогыг 0,3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн, ЦЕГ-ын орлогыг 0,3 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын төсөвт олгох, эмнэлэгт олгох санхүүжилтийн орлогыг 0,5 тэрбум төгрөгөөр, харьяа төсөвт байгууллагын өрийн орлогыг 0,3 тэрбум төгрөгөөр тус тус бууруулан төлөвлөсөн байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 2024 оны тодотгосон төсвөөс 631,4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

ХЗДХ-ийн сайдын урсгал зардал 426,4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 1 их наяд 705,9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэлт урамшуулал 247,8 тэрбум, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 19,3 тэрбум, хангамж бараа материалын зардал 15,5 тэрбум, нормативт зардал 50,7 тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 37,8 тэрбум, бараа үйлчилгээний бусад зардал 15,2 тэрбум, төрийн өмчит байгууллагад олгох татаас 2 тэрбум төгрөг тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 18 төсөл, арга хэмжээнд нийт 129,7

тэрбум төгрөгийг улсын төсвөөс 3 төсөл, арга хэмжээнд нийт 22,7 тэрбум төгрөгийг гадаад зээл тусламжийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийн багцын урсгал зардлын төсвийг 9,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 27,3 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэлт урамшуулал 5,5 тэрбум, бараа үйлчилгээний бусад зардал 0,9 тэрбум, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн төсөв 0,7 тэрбум төгрөг тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 3 төсөл, арга хэмжээ нийт 5,6 тэрбум төгрөгийг улсын төсөв санхүүжихээр төлөвлөсөн байна.

ШЕЗ-ийн даргын урсгал зардлын төсвийг 123,2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 276,4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 62,3 тэрбум, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 8 тэрбум, эд хогшил, урсгал засварын зардал 11,7 тэрбум, бараа үйлчилгээний бусад зардал 10,1 тэрбум, бусад урсгал шилжүүлэх 21,3 тэрбум төгрөг тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 2 төсөл, арга хэмжээнд нийт 43,3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Шүүхийн сахилгын хорооны даргын урсгал зардлын төсвийг 1,3 тэрбум төгрөгөөс 13 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 6,1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 0,8 тэрбум, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 0,2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 1 төсөл, арга хэмжээ нийт 0,3 тэрбум

төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

УЕП-ын урсгал зардлын төсвийг 30,6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 129,9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 22,7 тэрбум, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 2,3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 4 төсөл, арга хэмжээнд нийт 15,8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

ХЭҮК-ын даргын урсгал зардлын төсвийг 6,6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 12,2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 3,7 тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 0,5 тэрбум, бараа үйлчилгээний бусад зардал 1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 1 төсөл, арга хэмжээнд нийт 3,4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

АТГ-ын даргын төсвийн багцын урсгал зардлын төсвийг 10,1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 55,5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал нь 8,5 тэрбум, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 1,4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 2 төсөл, арга хэмжээ, нийт 2,7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23

дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Загджав даргад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сан сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Ингээд хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Нарантуяа-Нара гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Хууль зүйн сайдаас нэг асуулт асуух гэсэн юм. Энэ бид нар Тамгын газраас тараагдаж өгсөн энэ манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгаа асуудлуудаас яамны нийт зардлыг байгууллагаар нь ингээд харсан хүснэгт байна. Тэгээд энэ дээр 1 дүгээрт, ШШГЕГ-ын зардал 24 оны төсөвтэйгөө болон 24 тодотголтойгоо бүр ингээд харьцуулахад бараг 6, 7 дахин өсчихсөн байгаа. Үүний учир шалтгаан нь юу юм бол? Ард талд нь харахаар аймгуудын болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа тэр цагдан хорих газрууд эд нарын зардал хасагдсан байгаа. Энэ нэмэгдээд ерөнхий газар дээрээ ингээд төсөв нь тавигддаг болчихсон юм уу? Үүний учир

шалтгааныг 1 дүгээрт тайлбарлаж өгөөч.

2 дугаарт, сая Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай бид нар хууль анх ээлжит бус чуулганаар, анхны анхдугаар чуулганаар хэлэлцэхдээ бүх яамнуудын бүх сайд нарын чиг үүргийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах чиг үүргийг бүгдэд нь нэмж өгсөн. Тэгэхээр энэ агаарын бохирдлыг бууруулах бол бүхий л Засгийн газар, яамнуудын хүчин чармайлт чиг үүрэг, үндсэн чиг үүргийн нэг нь болсон. Тэгэхээр энэтэй холбоотойгоор та бас мэдэж байж магадгүй. Ер нь нийслэл Улаанбаатар хотод бид түүхий нүүрс түлэхгүй ээ гээд 2017 оноос хойш ингээд хүчин чармайлт хийгээд иргэд маань ч гэсэн сайжруулсан түлш түлээд явж байгаа. Гэтэл яг үнэнийг хэлэхэд төрийн байгууллагууд, тэр дундаа ШШГЕГ-ын харьяа 33 уурын зуух нийслэл Улаанбаатар хотод хүртэл Багануурын түүхий нүүрсийг түлж байгаа.

Тэгээд энэ түүхий нүүрс түлж байгаа маань өөрөө агаарын бохирдол маш өндөр бохирдуулагч элементүүдийг гаргаж байдаг. Тэгээд үүнийг удаа дараа уг нь Засгийн газарт бас Засгийн газраас ч гэсэн энэ Шүүхийн ерөнхий шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрыг төсөв нь болохоор Хууль зүйн яаман дээр байдаг учраас энэ түүхий нүүрс түлэхгүй байх, энэ технологийн өөрчлөлт нь байдаг юм уу, уурын зуухнуудаа шинэчлэх энэ ажлуудыг хийхээр бас тогтоол гарч байсан. Энэ ажил хэр шатандаа явж байна? Үүнийг 25-26 оны энэ жилд бүгдийг нь өөрчлөөд ядаж, та чиг үүргийнхээ хүрээнд агаарын бохирдлыг багасгах таны гол хийх ажил бол би энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 33 уурын зуухыг л түүхий нүүрс түлдэггүй болгох гэж харж байгаа. Энэ дээр та ямар ажил төлөвлөж байна гэдгийг бас асуумаар байна? Баярлалаа.

Д.Цогтбаатар: 1 дүгээр асуулт ШЕЗ-өөс. Тийм, Хууль зүйн сайдаас. 2 асуулт тэгээд хоёулаа гэсэн үг байна шүү. ШШГЕГ-тай холбоотой. Тэгье. Хууль зүйн сайдын микрофоныг өгье. Алтангэрэл сайдын.

О.Алтангэрэл: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ удаагийн төсөв дээр энэ ШШГЕГ-ын төсөв жоохон нэмэгдсэн харагдаж байгаа. Ер нь бол манай улс хууль зүйн салбар, систем байгууллагууд, тэр дундаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын системийн хэмжээгээр сүүлийн жилүүдэд ерөөсөө өөрсдийгөө л аргалж байвал ингээд ер нь болно гэсэн байдалтай хандаж ирсэн юм байна лээ.

Тэгээд үүнтэй холбогдуулаад олон жил ашиглаж байгаа хорих ангиудын ерөнхий нөхцөл байдал муудсан. ХЭҮК-ын удаа дараагийн шалгалтуудаар энэ хорих ял эдэлж байгаа хоригдлуудын орчин нөхцөл болохгүй байна аа, хүний эрхийг зөрчиж байна аа гэсэн ийм дүгнэлт авч байсан. Тэгээд холбогдох хууль тогтоомжуудаар бас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын орон тоонууд 400 гаруйгаар нэмэгдсэн зэргээс шалтгаалаад энэ удаагийн төсөв өссөн байдалтай орж ирж байгаа. Энэ бол зөвхөн энэ жилийн энэ өсөөд байгаа биш өнгөрсөн жилүүдэд ер нь энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад энэ ял эдлүүлэх байгууллагадаа санхүү, мөнгөний хувьд өөрсдөө дотоод орлоготой юм чинь болгоно биз дээ гэж хандаж ирсэн энэ он жилүүдийг засаж залруулж байгаа хэлбэр гэж бодож байгаа юм.

Тэгээд манай Хүний эрхийн Үндэсний комиссоос хүртэл Сангийн яам, холбогдох байгууллага руу энэ асуудал дээр анхаараач ээ гэсэн ийм байдалтайгаар нэлээн бичиг, тоот өгсөн, шаардлагууд тавьсан. Бид нар бас нэлээн судалж байж, энэ удаагийн төсөв орж ирсэн шүү гэдгийг тодотгож хэлье ээ. Таны асуултад.

Тэр яндантай холбоотой хэчнээн яндан байна, ямар арга хэмжээ авахтай холбоотой асуудал дээр Намсаманд дарга хариулчих.

Дарга аа, хэдэн номерын микрофон дээр суулгах вэ, та хэл.

Д.Цогтбаатар: Аль микрофон уу? 7 номерын микрофон. 7 номерын микрофон өгье.

Юу яая, дараа нь тодруулах боломж байгаа учраас тэгж асууя. Энэ 7 номерын микрофоноо ярьж эхлэхээс нь цагаа тоолоорой.

Баярлалаа. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга хурандаа Намсаманд.

Өмнөх жилүүдэд энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ялангуяа Улаанбаатар хотын хорих анги ААН-үүдийн уурын зуухны асуудлыг бол үе шаттайгаар шинэчилж ирсэн. Сайжруулсан түлш түлж байгаа юм. Хуучин бол түүхий нүүрс түлдэг байсан. Одоо энэ уурын зуухнууд бол сайжруулсан нүүрс. Гэтэл нөгөө өмнөх уурын зуухнууд нь, өмнөх уурын зуухнууд нь түүхий нүүрсэнд зориулсан уурын зуух учраас нөгөө сайжруулсан түлш түлээд ирэхээр нөгөө яндангаа сорчихдог, шүүрээ сорчихдог, нөгөө нүүрс түлэх юм бол нэг 5 жил гэдэг юм уу, 7 жилийн ашиглалттай гэж тооцож байсан уурын зуухнууд чинь нөгөө сайжруулсан түлш түлэхээр хоёрхон жилийн дотор уурын зуухаа, бидний хэлдгээр, энгийн хэллэгээр сороод дуусгачих юм. Тийм учраас энэ уурын зуухнуудыг сольё гэж асуудал оруулж ирж байгаа.

Дараагийн дугаарт, дараагийн дугаарт энэ жил бид бүхэн бас үе шаттайгаар шийдэж байгаа. Түрүүн хэлсэн. Энэ жил 22 уурын зуухаа сольё гээд тендер зарлачихсан. Тендерийн шалгаруулалт нь явагдаж байгаа ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу? Тэгье. 7 номерын микрофон өгье.

А.Намсаманд: Энэ жилийн тухайд 22 уурын зуухаа энэ ондоо багтааж шинэчилчихнэ. Тэгээд үлдсэн бусад уурын зуухнуудын асуудлыг ирэх оны төсөв дээр тавьж өгөөч ээ, шийдье ээ гэдэг саналыг оруулсан байж байгаа. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье, гүйцээж асууя.

О.Номинчимэг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын төсөв зардал нь шүү дээ, тийм ээ. Алтангэрэл сайд аа, ингээд харахаар 489 хувь нэмэгдчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр та хэлж байна. Ер нь хөрөнгө оруулалт хэрэгтэй гээд. Энэ зардал чинь яг 489 хувиар нэмэгдэж байгаа чинь яг юу юунд зарцуулагдах гэж байгаа юм бэ? Тэгээд бас түрүүний асуултад асуусан. Зарим орон нутагт байгаа гүйцэтгэх газар, хорих ангийн төсөв байхгүй болсон байгаа. Энэнийхээ учир шалтгааныг бас нэмээд тайлбарлаад өгөөч.

Уурын зуух дээр болохоор 33 зуухныхаа 22-ыг нь та бүхэн ул ширмийг нь солиод хөрөнгө оруулалт хийгээд түүхий нүүрс түлэхгүй байх арга хэмжээ энэ жилдээ авч байгаа гэж ойлголоо. Зөв үү? Тэгээд ирэх оны үлдсэн 11 зуух дээрээ ямар төсөв хөрөнгө тавьсан юм бэ? Яг түүхий нүүрс түлэхгүй, хаягдал утааны стандартыг барих хэмжээнд болгож байгаа юу? Та бас энд протоколтой явж байгаа учраас би яг дараа жил энэ гүйцэтгэлийг бас асуумаар байгаа учраас яг хэлээрэй гэж хэлмээр байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофон эхлээд өгье. Дараа нь Алтангэрэл сайд хариулаарай.

А.Намсаманд: Баярлалаа. Тэгээд дахиад уурын зуухтай холбогдуулаад хэлэхэд үлдсэн уурын зуухаа бид нар өөрсдөө энэ 22-ыг энэ жил шийдэж байна, үлдэгдлийг нь бас шийдүүлье гэж байгаа. Энэ уурын зуухнууд нь нөгөө түүхий нүүрснийх нь, баяжуулсан нүүрснийх болгож өөрчилж байгаа. Уурын зуух болгон дээр нь хуучнаар мэргэжлийн хяналтын байгууллага, одоо агаарын бохирдол хариуцсан нийслэлийн төр захиргааны байгууллагын алба хаагч нар хяналт тавьж байгаа, тухай бүр, сар болгон. Утаан, усан шүүр ч гэдэг юм уу яг энд зориулалтын мэргэжлийн шүүр, утаа барьдаг, тогтоодог энэ хяналтыг нь хэрэгжүүлж ажиллаж байгаа.

Таны асуултад энд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төсөв нэмэгдсэн гэдэг асуудал дээр бас энэ Монгол улсын Засгийн газрын Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-өөс 28 оны урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүний дотор цахим хяналтын төвийг үйл ажиллагааг сайжруулна аа, пробасын тогтолцоог хэрэгжүүлнэ ээ гэдэг ажлууд орчихсон. Үүнээс гадна 2017 оны 7 сарын Эрүүгийн хуулийн ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофоныг гүйцээгээд өгье.

А.Намсаманд: Пробасын тогтолцоо. Дээр нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга дээр хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээ манай байгууллагын чиг үүрэг дээр нэмэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл нөгөө таслан сэргийлэх арга хэмжээ, батлан даалтын хязгаарлалт тогтоосон. Өнөөдрийн байдлаар ингээд шүүх дээр шүүх хурал нь болох гээд байдаг, ирдэггүй, олон 100 хүн байгаа. Энэ улсуудыг ирдэг, сурдаг ажил манай дээр ирж байгаа юм. Тэгвэл энэ улсуудын эрэн сурвалжлах хүн хүч, машин, тоног төхөөрөмжийн зардал энэ дээр орж

ирсэн байж байгаа юм. Нэмэгдэж. Тийм, хариулж дууслаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Сүүлийн жилүүдэд бол энэ ШШГЕГ-ын урсгал зардал ерөөсөө нэмэгдэж байгаагүй ээ. Энэ удаад бол энэ орон тооны нэмэгдэл, урсгал зардал дээр бол Номинчимэг гишүүний ярьж байгаа гол нэмэгдэл нь байгаа юм. Тэгээд энэ нэмэгдэж байгаа төсөв нь ерөнхий газар дээрээ байгаа төсвийн хуваариар салбарууддаа хуваарилаад, хуваарилагдаад явна аа гэдгийг тодруулж хэлье ээ.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас асууя. Кибер аюулгүй байдлын зардал гээд хасагдсан байгаад байгаа. Одоо бид нар чинь нөгөө үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал маань 10 онд батлагдаад явсан, зарим зорилго тавьсан хэрэгжилт нь 20 онд биелэгдэх ёстой байтал биелээгүй 4 жил болчихсон. Тэгээд миний хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт бас энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэх чиглэлээр саналаа хүргүүлээд байгаа. Энэ бол мэдээж том цар хүрээтэй ажил учраас ингээд өргөн далайцтай судалгаа шинжилгээ олон институцүүд ороод явах байх.

Энэ кибер аюулгүй байдал буюу энэ цахим аюулгүй байдлын зардал нь хасагдсан гэж орж ирж байна, 1.

2 дугаарт нь болохоор тэр эмнэлэг, 25 оны төсөвт эмнэлэг таслан сэргийлэх ялын өөрчлөлттэй холбоотой хорихоос өөр төрлийн ял, эрэн сурвалжлах ажилд шаардлагатай зардал бас хасагдсан гэж байгаа. Энэ 2.

3 дугаарт нь болохоороо цахим хяналт ашиглан хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээг 25 оноос хэрэгжүүлж эхлэх гэж байгаа. Үүнтэй холбогдуулаад бас төсөв нь хасагдсан гэж байгаа. Тэр ШШГЕГ яг энэ хасагдсан гээд байгаа энэ төсвүүд дээр нэг тайлбар хийхгүй юу. Зүгээр яагаад эд нар шаардлагатай байсан талаасаа бас Байнгын хорооны хурал учраас, 1.

2 дугаарт, Сангийн яамнаас бас энэ ингээд зайлиггүй хасах шаардлагатай байсан уу гэдэг тайлбар авмаар байна.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд хариулах уу? Эс үгүй бол 7 дугаар микрофон. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас хариулах уу? 7 дугаар микрофон өгье.

А.Намсаманд: Баярлалаа. Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Энэ хасагдсан зардлууд нь ийм зардал байгаа юм. Түрүүн нөгөө Номинчимэг гишүүний асуусан асуултад хариулсан хариулттай давхцаад байгаа юм. Их Хурлаас баталсан нөгөө Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 20-24 оны хөгжлийн бодлогын баримт бичгүүд дээр нь цахим хяналтын төвийг байгуулж, пробазын тогтолцоог хэрэгжүүлнэ. Ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшиүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүй бол ялын бодлогыг хангах зорилгоор гэж байгаа.

Мөн түүнчлэн түрүүн хэлсэн, нөгөө энэ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад манай байгууллагын чиг үүрэг дахиад нэмэгдээд байгаа юм. Нөгөө хязгаарлаж тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулаад энэ нөгөө орон тооны асуудал, хүн хүчний асуудал, машин, техник тоног төхөөрөмжийн асуудал. Энэ нөгөө хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээ нь нөгөө цахим бугуйвч, цахим гавар хэрэгжинэ.

Тийм учраас энэ төрлийн зардлуудыг бид нар оруулж, санал хүргүүлсэн хэдий ч бас энэ дээр бас зарим зардлууд дээр бол хязгаарлалт хасагдсан тийм зүйл байгаа юм байна лээ.

Д.Цогтбаатар: Сүхбат юу, Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

С.Эрдэнэболд: Миний тодруулж асуух гэж байгаа юм Намсаманд хурандаа, ингээд хасагдчихлаа шүү дээ. Энэ чигээрээ явчих юм бол 25 оноос өгсүүлээд хууль хэрэгжүүлэх нөхцөл байдалд доголдол үүсэх үү. Үүсэх бол ямар доголдол үүсэх вэ? Энэ зайлиггүй байх ёстой тийм зайлиггүй шаардлага юу байгаа юм бэ гэдгээ л та тодорхойлоод хэлчих. Ерөнхий нөгөө алсын хараа гэхээс илүүтэйгээр яг тодорхой тооцоолол байна уу?

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофон өгье.

А.Намсаманд: Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя. Доголдол үүснэ. Хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээг манай байгууллага авч хэрэгжүүлж эхлэхээр хүн хүчний асуудалд, энэ хүн болгоны араас чинь хүн, машин унаа, техникээр улсын хэмжээнд, 21 аймаг, хот суурин болгонд л энэ хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа. Үүний араас манай байгууллага бүх л аймаг, сумдад үйл ажиллагаа явуулах учраас энэ чиглэлийн үйл ажиллагааг манай байгууллага шинээр авч хэрэгжүүлэхэд бол бас хүндрэл учирна. Хариулж дууслаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Сангийн яам 5 дугаар микрофон өгье.

Б.Жавхлан: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын төсвийг хассан гэдэг ойлголтыг ингэж ойлгох хэрэгтэй

болов уу. Өнгөрсөн оны жишээ нь 23, 24 оны суурь зардлуудаас бол огт хасагдаагүй, огт хасагдаагүй. Харин ч урсгал зардал дээр тодорхой хэмжээний нэмэгдэлт гарч ирж байгаа. Харин нэмэлтээр ирсэн хөрөнгө оруулалтын зардлуудыг аваагүй гэж ойлгох хэрэгтэй. Тэгэхээр үүнийг хасалт гэж ойлгож болохгүй. Аваагүй зарчмаа бол бид бүгдээрээ мэдэж байгаа. Ирэх жил бид бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлал энэ суурь зарчмаараа ирэх 30 жилийнхээ дэд бүтцийн суурийг нь тавьяаа гэдэг ийм л зарчмаар орж ирж байгаа. Тийм.

Тэгэхээр энэ тээвэр ложистик, зам, эрчим хүчин дээрээ түлхүү тавиад, манай 34 төсвийн ерөнхийлөн захирагч байдаг. Эндээс бүгд дээр нь яг өөр өөрсдийн чиглэлийн шинэ бүтээн байгуулалт, барилга байгууламжуудыг нэг жил хойшлуулж байгаа юм. Тэгэхээр тэр хасагдсан ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу, сайд. 5 дугаар микрофон. Гүйцээгээд хариулах уу, яах вэ?

Б.Жавхлан: Үгүй ээ, үгүй гүйцээчихсэн.

Д.Цогтбаатар: Тэгвэл Уянгахушиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахушиг: 2 асуулт байна.

1 дүгээрт, жсоохон танин мэдэхүйн шинжтэй асуулт байж магадгүй. Гэхдээ энэ нөгөө Хууль зүйн яамны төсөв дээр тоног төхөөрөмжийн зардлууд гэж байгаа. Тэгэхээр тоног төхөөрөмжийн зардлууд нь ерөнхийдөө хамгийн өндөр дүнтэй яваад байна л даа. Жишээлбэл ЦЕГ 37 тэрбум, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхий газар 21 тэрбум гээд. Тэгэхээр энэ тоног төхөөрөмжийн зардал нь байнга ингээд жил болгон гардаг зардлууд уу. эсвэл ингээд нэмэлтээр жишээлбэл систем хөгжүүлэлт ч гэдэг юм уу тийм ээ, шинээр тоног төхөөрөмж нэмэх гэдэг

дээр гарч ирдэг зардал юм болов уу? Үүнийг нэг тодруулж асуумаар байна.

2 дахь асуулт нь болохоор өмнө нь ч гэсэн яригдсан ШЕЗ-ийн төсөв Хууль зүйн байнгын хороогоор орсон дүнгээс 100 тэрбумаар хасагдчихсан байна. Энэ өөрөө хуулийн зөрчил үүсгэж байна шүү гэдэг асуудлыг Байнгын хорооны дарга маань ч гэсэн нэлээн олон удаа давтаж ярьж байгаа. Тэгэхээр энэ дээр яг тэр хасагдсан 100 тэрбум дээр яг ямар ямар зардлууд байсан юм бол оо гэдгийг ШЕЗ-өөс асуумаар байна.

Сангийн сайдаас болохоороо яг тэр зардлууд хасагдсан шалтгаан нь юу юм бол оо гэдэг ийм 2 асуулт байна.

Д.Цогтбаатар: ШЕЗ-ийн микрофоныг өгье. Наадах чинь байхгүй, 7 дээр солиод очоод суучих. 7 дугаар микрофон өгье.

Л.Энхбилэг: Байнгын хорооны дарга, гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Уянгахушиг гишүүний асуултад хариулъя. Манайх ШЕЗ нийтдээ 2025 онд нийт төсөв бол 420,8 тэрбум гэж саналаа өгсөн. Байнгын хороогоор яг энэ дүнгээрээ бол Сангийн яам дүнгээрээ батлагдаад, Сангийн яамд улсын төсөвт нэгтгүүлэхээр хүргүүлсэн. Эндээс хөрөнгө оруулалтаас хасагдсан нь болохоороо барилга, их засвар, тоног төхөөрөмж, бусад хөрөнгө гэдгээс бол нийт 43 аравны, 100,6 тэрбум хасагдсан юм. Энэ бол цэвэр нөгөө барилга, их засвар, тоног төхөөрөмж. Бусад хөрөнгө гэдэг нь 26 онд бид нар бас үлдсэн шүүхүүдээрээ барилгын асуудлаа шийдүүлэхийн тулд ТЭЗҮ хийлгэнэ. Тэрний зардал орчихсон байгаа юм. Хасагдсан дүнгээрээ барилга дээр 76,7, их засвар дээр 1 тэрбум, тоног төхөөрөмж дээр 22, бусад хөрөнгө гэдэг дээр 815,3 сая төгрөг нийлээд ингээд 100,6 тэрбум байгаа юм.

Д.Цогтбаатар: Сангийн сайдын микрофон өгье. 5 дугаар микрофон.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Тэрийг хууль зүйн зөрчил гэдгийг бидний талаас бол хүлээн зөвшөөрмөөргүй байна. Бид Засгийн газар төсөв төлөвлөх үүрэгтэй. Түүнийгээ төлөвлөхдөө бид ерөөсөө суурь хуулиа Төсвийн хуулиа л барьдаг. Хэрвээ салбар салбарын хуулийг бариад, салбар салбарын хуульд тааруулж төсвөө төлөвлөнө гэвэл ямар ч боломж байхгүй. Эдгээр салбар салбарын хуулиуд дээр, Шүүхийн тухай хууль дээр Хууль зүйн байнгын хороон дээр төсвийг нь төлөвлөдөг болгочихсон, бараг тийм заалттай байна. Засгийн газрын төсөв төлөвлөдөг тэр хэсэг ажил маань ингээд бүр шүүх болон ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон гүйцээгээд өгье.

Б.Жавхлан: Бүтцийн институцийн эрх мэдлийн асуудал юм шиг ингээд ороод ирчихсэн нэг ийм асуудал үүсээд байдаг юм. Тэгэхдээ бусад өөр хуулиуд дээр ч байгаа. Хуулийн заалт нь ийм байлаа гээд энэ чинь нэг л төсөв ярьж байгаа шүү дээ, Монгол Улсын төсөв гээд. Тэр дотроос бүүр түгжиж гаргаж ирээд хөдөлгөөнгүйгээр энэ тусдаа төсөв гэдэг ойлголт байхгүй. Бид нар Монгол Улсынхаа төсвийг төлөвлөхдөө бүх бүрэлдэхүүн хэсгүүдээ оруулаад л, ингээд л төлөвлөдөг учраас бид Төсвийнхөө хуулийг л суурь хуулиа бариад явдаг. Оруулж ирж байгаа энэ төсвийн тоо хэмжээ маань тэр 25 оны төсвийнхөө боломж хэмжээндээ төсвийн хүрээний мэдэгдэлтэй бүгдэд нь таарсан ийм л зүйл байгаа.

Урсгал зардлын хувьд бол хасагдаагүй. Нөгөө хөрөнгө оруулалтуудад нь ерөнхий зарчмаараа л шинэ зүйлүүд ороогүй байгаа гэсэн үг. Тийм.

Д.Цогтбаатар: Уянгахшиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахшиг: Энэ дээр түрүүхэн би яг нөгөө Төрийн байгуулалтын байнгын хороо дээр асууж байсан шүү дээ. Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний барилгад жишээлбэл 210 тэрбумыг төсөвлөчихсөн байгаа байхгүй юу. Тэр чинь цоо шинэ барилга шүү дээ. Хэн яг үйлчлүүлэх нь тодорхой биш, тийм барилга дээр 210 тэрбум төсөвлөгдчихсэн байхад яг шүүхийн барилга, байгууламжууд буюу иргэдийн үйлчлүүлдэг наад захын хамгийн шаардлагатай, нэн шаардлагатай барилгууд нь өөрсдөө халаалт, урсгал зардал байхгүй, засвар хийгдээгүй, шүүхийн байр нь өөрөө байхгүй, ийм байж байхад яахаараа яг энэ 100 тэрбумыг зайлигүй хасах шаардлага нь юу байсан юм бэ буюу хасаагүй ээ, зөвшөөрөөгүй гэдэг юм ярьж байгаа бол энэ дээр яг нарийн учир шалтгааныг л тодруулж мэдмээр байна л даа. Үнэхээр шинэ юм оруулахгүй байгаа юм бол тэр 210 тэрбумыгаа хасъя л даа.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Б.Жавхлан: Дахиад хэлэх үү? Гишүүний асуултад нэмж хариулъя. Өмнөх Байнгын хороон дээр би бас танд маш тодорхой хариулт өгсөн дөө. Уг нь. 25 онд тавигдсан байгаа тэр Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээ чинь шинэ биш шүү дээ. Сая тодотголоор эхлүүлж байгаа ажил. Өөрөөр хэлбэл 25 онд үргэлжилж байгаа ажил байхгүй юу. Энэ чинь Төсвийн хуулиараа үргэлжилж байгаа ажил. Тийм учраас шинэ зүйл бол биш 1 дүгээрт.

2 дугаарт, өнөөдөр яг тулгамдсан байгаа бидний хамгийн том асуудлуудын нэг энэ Улаанбаатар хотын түгжрэлийн асуудал байгаа шүү дээ. Үүнийг бид нар маш их ярьж, ойрын хугацааны бид нарын тулгамдсан асуудал аа гээд энэ рүүгээ ингээд ер нь Засгийн газрын энэ төлөвлөгөө, бидний баталсан хэрэгжүүлж эхэлж байгаа Улсын Их Хурал дээр батлагдсан энэ бүх зүйлүүд

дээр энэ өөрөө суурь үзэл баримтлал болоод орчихсон. Нийслэл дээр ч гэсэн ойрын жилүүдэд хийх онцгой анхаарах ажлуудын маань нэг нь өөрөө энэ болчихсон явж байгаа. Түүнээс биш эндэх байшин нь хуучраад хэрэглээгээ ашиглалт даахгүй болчихоод цоо шинэ сайхан шинэ барилга барих гэж байгаа зүйл огт биш юм байгаа юм шүү дээ, тийм ээ.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариултаа авъя, гэнэ ээ. Энэ Уянгахишиг гишүүн. ШЕЗ-өөс 7 дугаар микрофон.

Л.Энхбилэг: Сайд урсгал зардал дээр хасагдаагүй гээд байна. 1,6 цалингаасаа хасагдчихсан байгаа, урсгал зардал дээр. Тэгээд хөрөнгө оруулалт дээрээ 100,6 хасагдчихсан. 100,6 чинь өөрөө бид нар шүүх барилгагүй, байшингүй байхгүй юу. Барилга байхгүй, стандартын зориулалтын барилга байхгүй. Эмнэлэг дээр мэс заслын өрөө байдаггүйтэй адил шүүхэд шүүх хуралдааны танхим байхгүй бол хуулийн хугацаанд хэргийг шийдвэрлэх боломжгүй. Энэ хуулийн хугацаанд хэргийг шийдвэрлэнэ ээ гэдэг чинь иргэдийн нөгөө шүүхэд итгэх итгэлтэй холбоотой. Тэгээд саяын нөгөө хаврын чуулганаар орсон Шүүхийн тухай хуулийн ил тод байдал дээр чинь авлигатай холбоотой гэмт хэргийг чинь анхан буюу давж заалдах шатны шүүхээр нээлттэй явуулна аа гэсэн. Тэр тоног төхөөрөмжийн зардлууд байгаа байхгүй юу. Тэгээд тэр нь өөрөө хасагдчихсан.

Тэгэхээр бид нар тоног төхөөрөмжгүй юм чинь тэр хуралдааныг яаж нээлттэй, ард түмэнд ингээд явуулах юм бэ? Боломжгүй, зайлшгүй шаардлагатай юмаа л бид нар санал болгоод оруулж байгаа. Байнгын хороон дээр энэ хянагдсан. Хянагдсан төсвийг улс ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Нараа гишүүн Нарантуяа.

М.Нарантуяа-Нара: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр 1 дүгээр асуултыг Хууль зүйн яамны сайдаас ер нь энэ төсөвтэй холбоотой тавилга, тоног төхөөрөмжийн асуудлыг сая Уянгахишиг гишүүн маань бас асуулаа л даа. Тэгэхдээ түүн дээр бүр нэмэлтээр надад нэг зүйл бүр тодорхой болгомоор байна. Тэр нь жишээлбэл энэ улсын төсөв шүү дээ. Тэгэхээр зэрэг жил болгон 1 дүгээрт, тавилга тоног төхөөрөмжийн худалдан авалт хийж байна. Бид нар саяхан л гэхэд 24 оны тавилга, тоног төхөөрөмжийн төсвийг бас батлаад явуулсан. Одоо дахиад л орж ирж байна. Тэгэхээр энэ дээр тавилга, тоног төхөөрөмжийн худалдан авалттай холбоотой мэдээллийг нь ил тод болгоод, хаана, хэзээ, хэн, хэдий хэрийн ямар тоног төхөөрөмж авах вэ, авсан бэ гэдгийг ил тод харуулахгүй бол ингээд ашиглалтын хугацаа дууссан, элэгдлийн зардалтай гээд нэлээн үр ашиггүй худалдан авалтууд явагдаад байна.

Тэгээд үүний цаана чинь нөгөө тендер хүлээдэг хэсэг бүлгийн эрх ашиг бас байхыг үгүйсгэхгүй байх ийм хардалт гарч ирж байна. Мөн түүнчлэн худалдан авалт энэ тоног төхөөрөмжийн худалдан авалт дээрээ жишээлбэл цагдаагийн газарт мөрдөн байцаалт өгч байгаа иргэдэд камер эвдэрсэн, камер байгаагүй, камерын байршил буруу байсан гээд ийм өнгөрсөн бид нар хурлаар энэ ярилцсан асуудлууд байгаа. Энэ камержуулалтын асуудлаа бүрэн шийдсэн үү? Одоо хэн нэгэн иргэний эрх ашиг зөрчигдөөд, мөрдөн байцаалтын явцад дахин эрүүдэн шүүсэн гэсэн асуудал гарч ирэхгүй гэсэн баталгааг өгч чадах уу?

2 дугаарт, Сангийн яамны сайдаас асуумаар байна. Иргэдийн тулгамдсан асуудал бол зөвхөн түгжрэл биш ээ, сайд аа. Иргэдийн тулгамдсан асуудал бол эрх нь зөрчигдсөн энэ эрхээ хууль, эрх зүйн хүрээнд тийм ээ, хамгаалуулах, эрхээ сэргээлгэх ийм

зайшгүй тулгамдсан асуудал буюу шүүхээр өдөр болгон хэдэн 10 мянган иргэд үйлчлүүлж байгаа вэ гэдэг тоо статистик ч гэсэн маш өндөр байгаа.

Тэгээд энэ шүүхийн стандарт хангасан байрыг барина аа гэдэг нь зөвхөн шүүгчийг стандарт хангасан ажлын орчноор хангах тухай асуудал биш ээ. Энэ дотор үйлчлүүлж байгаа зөрчигдсөн эрхээ нэхэхээр хэдэн олон удаа давтамжтайгаар ирж байгаа иргэдийн эрх ашиг хөндөгдөж байгаа гэдгийг та ер нь бас бодолцоорой. Тэгээд энэ дээр бид нар бол манай Байнгын хороо бол энэ зардлыг юуг төсвийг бол зайлшгүй нөхөн оруулж ирэх ийм саналтай байж байна.

Тэгээд дээрээс нь Аудитын газраас нэг тодруулах юм байна. Энэ 25 оны улсын нэгдсэн төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлт дээр нэг ийм 80, 50 тэд тэд гэсэн үнэлгээнүүдийг өгчихсөн байна л даа. Тэгээд энэ үнэлгээнүүдийг яаж өгөөд байгаа юм бэ? Аргачлал нь хаана байна аа? Эхлээд одоогийн нөхцөл байдал, хүрэх үр дүн, хэмжих үзүүлэлт зэргийг харгалзан үзэж байна уу? Эс үгүй бол шууд ийм зүйлс хийсэн нь ийм дутагдалтай байна аа гээд үнэллээ ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 дүгээр асуулт хэнээс байлаа. 2 дахь нь Сангийн сайд. Хууль зүйн яам. Сангийн сайдаас байсан. Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Ашгүй түрүүний Уянгахишиг гишүүний асуудалтай давхцаж байгаа юм, зэрэг хариулчихъя. Энэ тоног төхөөрөмжтэй холбоотой асуудал энэ удаагийн төсөв дээр цагдаагийн байгууллага дээр байгаа тэр тоног төхөөрөмжийн зардал бол тавилга биш ээ. Тавилга ерөөсөө байхгүй. Энэ ямар тоног төхөөрөмжийн асуудалд яригдаж байна вэ гэхээр цагдаагийн байгууллага энхийг сахиулах ажиллагаанд оролцъё гэж байгаа юм. Өөрөө энэ цаанаас авдаг төлбөр мөнгөөр улсын

төсөвт буцаагаад зардлаа нөхнө. Албан хаагчдын ур чадвар сайжирна, нийгмийн баталгаа хангагдана гээд цагдаагийн байгууллага энхийг сахиулах ажиллагаанд оролцъё гэж байгаа том зорилгын хүрээнд тавигдаж байгаа тоног төхөөрөмж.

Дахиад ШШГЕГ дээр харагдаж байгаа тоног төхөөрөмж бол хорих байгууллагуудын эмнэлэг гэж маш хүнд хэцүү нөхцөлтэй байгаа юм. Нарантуяа-Нара гишүүн бид нар бас тэр эрүүдэн шүүсэнтэй холбоотой асуудлыг ярьж байхад бодит байдлаар манай шийдвэр гүйцэтгэлийнхэн хэлж байсан. Хангалт, тоног төхөөрөмж, орчин нөхцөл маш муу нөхцөлтэй. Тэгээд энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийн зардал байгаа юм.

Камержуулалттай холбоотой асуудал бол ер нь жишээлбэл энэ иргэдтэй холбоотойгоор, иргэдэд үзүүлж байгаа цагдаагийн байгууллагын энэ үйлчилгээ, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа иргэдэд ойрхон ойрхон шуурхай байх үүднээс олон асуудлыг цагдаагийн байгууллага өөрөө урсгал зардлаасаа зохицуулж байгаа юм. Тухайлах юм бол тэр мөрдөн байцаалттай холбоотой, яриа шууд бичдэг чимэгэ программ нэвтрүүлэх, бүх энэ стандартын шаардлага хангасан мөрдөн байцаалтын өрөөтэй болох гээд. Ингээд Монгол орон даяар цагдаагийн байгууллагын мөрдөн байцаалт явуулж байгаа нэгж болгон дээр энэ камер үйл ажиллагаа байгаа.

Үүнээс гадна дахиад энэ төсөв дээр суугаагүй ААНБ-тай хамтарч бас орон нутгийн төсвөөр Монгол орон даяар энэ бас ногоон бүс гээд камержуулах аян нэлээд өндөр хувьтай явж байна. Үүнээс шалтгаалан сум, суурин газар болгоныг бүрэн камерын хяналттай болгоё гэж цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийнхээ хүрээнд нэлээн

олон ажил хийж байгаа. Тэгээд яг энэ эрүүдэн шүүхтэй холбоотой, камержуулалттай холбоотой асуудлаар манай цагдаагийн байгууллага Нарантуяа-Нара гишүүний асуулт дээр тодруулаад хариулчих. Ноцтой асуудал хөндсөн учраас. Очбадрах хурандаа.

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофоныг өгье.

Мөрдөн байцаах албаны дарга, хурандаа Очбадрах. Бид нар яг сая гишүүний хэлдгээр мөрдөн байцаах алба, цагдаагийн байгууллагын хэмжээнд дүүрэг, орон нутаг, нийслэлийн хэмжээний мэдүүлэг авах өрөөг бид нар өөрсдөө дотооддоо хянаж, шалгаж үзсэн. Үндсэндээ нэг 417 мэдүүлэг авах өрөөг бид нар 849 мэдүүлэг ав авах өрөө болгож нэмэгдүүлсэн. Шалтгаан бол мэдээж иргэдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, дээрээс нь мэдүүлэг авч байгаа мөрдөгч буюу цагдаагийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хамгаалах.

Дээрээс нь бид нар 849 өрөөг прокурорын байгууллагатайгаа хамтраад мэдүүлэг авах зөвшөөрлийг албан ёсоор авч байршуулсан.

Мөн Эрүүгийн хуулийн 11.6.1 буюу хөнгөн хохирол учруулах гэмт хэргийг ЦЕГ-ын даргын тушаалаар энэ хороо хариуцсан хэсгийн байцаагч нар эрүү ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофоныг гүйцээгээд өгье.

П.Очбадрах: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндсэндээ бол процесс явуулах эрх хэмжээ олгогдсон. Үүнтэй холбоотойгоор бүх хороонд үүрэг гүйцэтгэж байгаа хэсгийн байцаагч нарын өрөөг бид нар камержуулсан байгаа.

Тэгэхээр ер нь цагдаагийн байгууллагын даргын тушаалаар бид нар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код өөрчлөлт оруулаад стандартаа баталсан. Прокурорын байгууллагаас ч гэсэн мөн ялгаа байхгүй энэ мэдүүлэг авах өрөөний стандартыг баталж, баталгаажуулж өгсөн байдаг. Үүнд нийцүүлэн бид нар бүх мэдүүлэл авах өрөөг 2-3 камертай болгож, ингэж бүрэн дуусгасан байгаа. Энэ бол цагдаагийн байгууллагын үндсэн өөрийнхөө төсвийн хөрөнгөөр шийдвэрлэсэн байгаа. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Уянгахушиг гишүүний асуултад бас түрүүн Алтангэрэл сайд давхар би хариулчихлаа гэж ойлголоо.

Ингээд асуулт асууж, хариу. Сангийн сайдаас юу асуулт асуусан байсан. Сангийн яам 2 дугаар микрофон өгье.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Яах вэ, зарлага талдаа ингээд нөгөө бид мэдээж хэрэг төрийн үйлчилгээ гэдэг бол бүгд хэрэгцээ шаардлагатай. Бид бүгдийг сайжруулахыг хүсэж байгаа. Үүний төлөө явж байгаа.

Нөгөө талдаа бол орлогын хэрэгцээ шаардлага байдаг. Энэ дагуу ингээд бид нар зарлагаа төлдөг. Яг Уянгахушиг гишүүний асуусан тэр цалинтай холбоотой асуудал бол яаж явдаг вэ гэхээр манай дээр бид нар бол төрийн албан хаагчдын цалин хөлсний цахим системийг нэвтрүүлсэн байгаа. Яг энэ цахим системээр яг төрийн албан хаагч болгоныг бид нар ингээд нэг бүрчлэн ингээд тооцоод ажилласан жил, тэтгэвэрт гарах хугацаа гэх байдлаар энэ дээр зөрчил гарахгүй байх талаар бол ингээд явдаг байгаа. Үүн дээр бол бид нарын тооцсоноор 1,6 тэрбум төгрөгөөр бол энэ зардал буурсан. Нөгөө

талдаа бол энэ зардал маань бол 1,2 тэрбум төгрөгөөр байр ашиглалтын зардал нь нэмэгдсэн байгаа.

Ингээд зөрөөгөөр 400 сая төгрөг ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Нараа гишүүн хариулт хангалттай юу? Нараа гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Уг нь бол энд эрх нь зөрчигдсөн иргэний эрхээ сэргээх, эрхийг нь хамгаалах төрийн үйлчилгээний асуудал явагдаж байгаа шүү дээ. Тэгэхээр шүүх өөрөө байргүй байна. Түүн дотор хэдэн мянган иргэн эрхээ сэргээх үйлчилгээ, төрийн үйлчилгээ авахаар өдөрт хэдэн давтамжтайгаар хэдэн иргэн орж ард гардаг юм бэ гэхээр энэ төрийн үйлчилгээг бид нар хангаж өгч чадахгүй байна гэсэн асуудал болж байна.

2 дугаарт, би Аудитын газраас энэ үнэлгээ, дүгнэлтийн аргачлалынхаа юуг гаргаж өгөөч ээ гэж асуусан сан байгаа. Тэгээд тэр аудитын юун дээрээ болохоор зэрэг нэг юм нэмээд хэлчихмээр байна. Тэгээд төсөв өртөг нэмэгдэх бас нөгөө хугацааны тухай дурдаж байгаа бас хэрвээ амжилтгүй хэрэгжвэл хэрхэн нөлөө үзүүлэх тал дээр шинжилгээ дүгнэлтийг нь бас Аудитын газраас авмаар байна. Өмнөх хариулт асуулттайгаа нэг нэгдсэн хариулт авъя.

Д.Цогтбаатар: Сангийн яам гүйцээгээд хариулчих. Тэгээд дараа нь Аудитын газар хариулъя. Сангийн яам 2 дугаар микрофон уу?

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Хөрөнгө оруулалтын хувьд улсын хэмжээнд нэг зарчим баримталсан байгаа. Яг тэр зарчмынх нь дагуу шинээр хөрөнгө оруулалт бол 2025 ондоо байхгүй байхаар. Гэхдээ өмнө нь хэрэгжүүлж эхэлсэн бүх хөрөнгө оруулалтаа дуусгах, энэнийхээ үр нөлөөг тооцох, энийгээ үзэх

ийм зорилгоор хуучин хөрөнгө оруулалт дээрээ илүү анхаарч ажиллах, дээрээс нь илүү дараачийн ээлжид Монгол Улс эдийн засгаа томруулах ийм том хөрөнгө оруулалтуудыг бид нар тавьж орсон байгаа. Энэ мега төслүүд үйлчилж байгаа. Ийм хөрөнгө оруулалт болсон байгаа. Энэ зарчмынх нь дагуу Засгийн газраас ирэх оныхоо төсвийг бол 25 оны төсөв боловсруулаад ингээд өргөн барьсан байгаа.

Д.Цогтбаатар: Аудитын газар 4 дүгээр микрофон.

Д.Загджав: Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Тэр 50, 80 гээд байгаа нь бол ер нь 2024 оны төсвийн дүгнэлтэд бид нийт 15 зөвлөмж, 2 албан шаардлага өгсөн байгаа. Олон улсын аудитын стандарт гэж байгаа. Тэр дагуу өгсөн хувь, хэмжээ юм. Ер нь бол цаашид зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулалтаар Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы төгсгөлд Улсын Их Хурлын дарга бас онцгойлон үүрэг өгсөн байгаа. Энэ дагуу бас энэ зөвлөмжийн хэрэгжилт сайжирна аа гэж ойлгож байгаа. Энэ рүү чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч явна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Тэмүүжин, Номинчимэг гишүүнээр тасаллаа. Уянгахушиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахушиг: Саяын Сангийн яамнаас өгч байгаа тайлбаруудыг бол ерөнхийдөө бүгдээрээ сонссон байх. Тэгэхээр ер нь өөрөө төрийн чиг үүрэг юу юм бэ? Төрийн албаны төрийн үйлчилгээ гэж ярьдаг шүү дээ, тийм ээ. Тэгэхээр үүний чиг үүрэг юу юм бэ гэдэг дээр бол бид нар яалт ч байхгүй энэ асуулыг дахиж тавих ёстой харагдаж байна л даа. Шинэ төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж

эхлэхгүй ээ, хуучныгаа үргэлжлүүлнэ ээ гэдэг юм ярьж байна. Гэтэл энэ өөрөө шүүхийн үйлчилгээ гэдэг юм чинь цоо шинэ гараад ирсэн үйлчилгээ юм уу, угаасаа үзүүлж байх үйлчилгээ. Энэ үйлчилгээ өөрөө стандартын дагуу явж байх ёстой. Энэ стандартын дагуу төрийн үйлчилгээг үзүүлэхийн тулд тэр зардлыг төсөвтөө суулгаж явж байх л ёстой. Жишээлбэл эмнэлэг байна, боловсрол байна, шүүх байна. Энэ нь зайлиггүй иргэддээ үзүүлдэг үйлчилгээ шүү дээ. Тэгэнгүүт энэ шинэ байшин барих гээд байна. Өөрөөр хэлбэл хууль батлагдчихаад байдаг. Шүүхийн ерөнхий шүүхийн хууль батлагдчихаад байдаг. Үүний дагуу орон нутагт шүүхтэй байх хэрэгтэй байна. Тойргийн шүүхүүд өөрчлөгдөж байна.

Дээрээс нь тэр тоног төхөөрөмж байна, ил тод байх ёстой, буцаагаад тэрийг иргэд мэдээллээ авч байх ёстой. Гэтэл тэр юмнуудыг тэр тоног төхөөрөмжийн зардлыг шинэ төслийн зардал гэдгээр оруулаад тийм ээ, шүүхийн тэр үйлчилгээ сайжрах ёстой. Одоо энэ дээр мэдэхгүй байх шиг байна л даа. Жишээлбэл шүүх хуралдааны танхим байхгүй учраас хүрэлцээгүй учраас шүүгчийн өрөөнд хуралддаг юм шүү дээ. Буцаагаад ингээд иргэдийг аваачаад чихцэлдүүлж зогсоож байгаад тэгээд хурал болдог байхгүй юу. Тэгэхээр тэр өөрөө үйлчилгээгээ хангалттай үзүүлж байна гэж үзэж болох юм уу?

Тэгэхээр энэ дээр үнэхээр бид нар дахиж энэ асуудлыг хөндөж ярихгүй бол болохгүй байна. Энэ төрийн чиг асуудалд хандаж байгаа хандлага бол өөрөө маш буруу байна. Тэгээд удаа дараа хэлээд байгаа тэр яагаад тэр 210 тэрбумын нэг цэгийн үйлчилгээг яриад байна вэ гэхээр тэр чинь өөрөө яг иргэд хэзээ, хаана аль улс иргэдэд зориулаад байгаа нь тодорхойгүй. Нөгөө туннел барихаар хотын иргэд очих гээд байгаа юм уу. Тийм юман дээрээ болохоор төсвөө тавьчихдаг. Тэгсэн мөртөө наад захын хэрэгцээтэй байгаа тэр засвар, үйлчилгээ

дээрээ, урсгал засвар дээрээ, тэр хөрөнгө оруулалтын зардал дээрээ төсвөө оруулж ирдэггүй байгаа чинь өөрөө төрийн төсвийн өөрөө зөв бодлого юм уу. Ийм л юм бодогдож байна даа, ер нь бол.

Д.Цогтбаатар: Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Сангийн яамныханд хандаад бас нэг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс энэ Их Хурлын дэд даргын харьяанд байдаг байгууллага. Тэгэхээр ер нь бүх байгууллагуудын ер нь бүх төрийн байгууллагуудын бүгдийнх нь зардал нэмэгдсэн. Ганцхан газар 80 хувиар хасагдсан байгаа. Өөрөөр хэлбэл өнгөрсөн жил 8,3 тэрбум төгрөгийн зарлагатай байсан бол энэ жил 1,4 тэрбум болж багассан байгаа. Өөрөөр хэлбэл 6,9 тэрбумаар багассан гэсэн үг.

Тэгэхээр энэ байгууллага дээр бас тодорхой хэмжээний өөрөөр хэлбэл төсвийг чинь бас хэмнэж өгч байна шүү дээ. Тэгэхээр энэ байгууллага дээр бас тодорхой хэмжээний үйл ажиллагааны болон бусад бусдаар гүйцэтгүүлэх ажил зэрэг бас нэг доголдож байгаа нэг нэлээн хэдэн хөрөнгө оруулалт энэ тэр нь бас нэг доголдохсон тийм юм байгаад байгаа. Тийм учраас нэгэнт л энэ 6,9 тэрбумыг хэмнэж өгч байгаа учраас тэр ажлууд дээр нь бас нэг ажлын хэсэг дээр ялангуяа Ганбат дарга аа, та анхаарч байгаад энэ дээр нэг 300 орчим сая төгрөгөөр нэмэгдүүлэх зайлиггүй шаардлага байгаа. Тэрийг нь та нэг, та нар хоорондоо ярилцаж байгаад ямар аргаар гаргаад ишийдэх юм, ямар зардлаас хасаж байгаад яаж хийх юм, тэрийг нь яачхаарай.

Би уул нь зарчмын зөрөөтэй санал гаргая гэсэн чинь энэ дэгийн хуулиар 2 өдрийн өмнө гаргадаг болчихсон байна шүү дээ, тийм ээ. Тэгээд уул нь Байнгын хороон дээр тэгж гаргадгийг нь мэдэлгүй, энэ дэг хамгийн сайн дэг мэддэг байж байж тэгээд хоцорчихлоо.

Тэгэхээр энэ дээр бас нэг Ганбат дарга аа, нэг та бодож байгаад ямарваа нэгэн байдлаар нэг тэр асуудлыг шийдвэрлэх талаар ажиллаарай. Би бас зарчмын зөрөөтэй санал гаргаад өгчихнө өө. Ажлын хэсэг дээр. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо бол энэ шүүх эрх мэдлийн шинэчлэлийг дэмжих, ялангуяа иргэдийн шударга шүүхээр шүүлгэх энэ эрхийг баталгааг хангах хүрээнд тууштай бодлогын дэмжлэг сүүлийн жилүүдэд бол үзүүлсээр ирсэн байгаа. Энэ дээр мэдээж, Сангийн яам, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо энэ хууль батлагдсанаас хойш ойлгоцлын зөрөө ч гэж хэлж болохгүй л дээ. Аль аль нь тэнд буруу юм байхгүй байгаад байгаа юм, үүсдэг. Парламент бол нөгөө Засгийн газраас шүүх эрх мэдлийн бас нөлөөллийг дархлааг баталгаажуулах утгаараа Хууль зүйн байнгын хороо шууд Засгийн газраар дамжуулахгүйгээр шүүхийн бас төсвийг хянаж ингэж явж байгаа. Энэ хүрээнд бол яах вэ, тэр том тоо яригдаад байгаа нь энэ шүүхүүдийн байр нөхцөл үнэхээр олон жилийн турш, энэ чинь 7 жил хөрөнгө оруулалт нь нойл Улсын Их Хурал батлаад явснаас болоод асуудал бугширсантай л бас холбоотой. Ийм тийм том нэмэгдэл болж гарч ирээд байдаг ийм зовлонтой.

Зөвхөн Сангийн яамны бас хүрээнд хянагдсан байдлаар Улсын Их Хурал хэлэлцье гэхээр урьд урьдын жишгүүдээс харахаар энэ Монгол Улсын шүүх Сангийн сайдаас ингээд царай алдчихсан, хараат болчихдог, ийм болчихоод байгаа юм.

Тэгэхээр тэр нөлөөллөөс нь парламент өөрөө бас үгтэй, шүүх эрх мэдлээ бас хамгаалж байх, тэгээд энэ зовлон дунд бол бас зүй зохистой шийдвэрүүд бас гарч явах байх аа гэж

ингэж бодож байгаа. Яах вэ, төсвийн хувьд бол жишээлбэл гишүүд бас асуугаад байх шиг байна. Шийдвэр гүйцэтгэл бол бас яг энэ шүүхтэй адилхан. Сүүлийн нэлээн олон жил нөгөө бусад агентлаг, газруудаа бодвол орхигдоод явчихсанаас улбаалаад бас энэ 25 оны хувьд бол бас их тийм том харагдаад байгаа тал байхыг бол үгүйсгэхгүй.

Тэгээд олон улсын шаардлага ч гэсэн энэ эрүүдэн шүүж байна. Ялангуяа энэ хорих байгууллагууд дээр хүний эрхийг хангах, манай улсын тухайд бол энэ сүүлийн жилүүдэд хүнийг илүү хорьж, шийтгэхээс илүүтэй, зорчих эрхийг нь хязгаарлах “цахим бугуйвч” гээд Тэмүүжин сайд тэр үеэс анх эхлүүлсэн. Энэ арга хэлбэрүүдийг түлхүү ашиглаж, энэ хүний эрхийг бас хангая гэдэг бодлогын хүрээнд бид бол орон тоо, тоног төхөөрөмжийнх нь асуудлыг бол бас шийдэх үүрэгтэй болов уу гэж үзэж байгаа. Яагаад гэхээр энэ дээр гарч байгаа зардал маань эргээд хүний эрхийг бас 1 дүгээрт, хамгаалах, нөгөө талаасаа заавал энэ чинь хорьж байна гэдэг чинь өөрөө дараагийн дахиад илүү их зардал гаргахаас бас урьдчилан сэргийлээд байгаа юм.

Тэгээд манай шорон чинь бол өнгөрсөн 20 жилийн хугацаанд 4-5 жил болоод дүүрээд байсан байхгүй юу. Одоо бол дүүрэхээ больчихсон шүү дээ. Тийм. Энэ чинь бол маш их зардал гардаг. Тийм учраас энэ дараа дараагийн бас гэмт хэрэг зөрчлөөс илүү хүнд гэмт хэрэгтнүүдийг бэлтгэхгүй байх талаасаа, нөгөө талаасаа бас энэ хүнлэг, энэрэнгүй байх, ял оновчтой байх, тохирсон байх гэсэн энэ орчин үеийн техник, технологийг бас ашиглах гэдэг талаасаа энэ бол бас бодлогын зөв чиглэл байна аа гэж ингэж үзэж байгаа.

Тийм учраас төсвийг бол бас хянагдаж орж ирсэн хүрээнд нь дэмжиж байна.

Д.Цогтбаатар: *Нанбат гишүүний микрофоныг өгье.*

Д.Ганбат: *Та бүхний өглөөний мэндийг мэдье ээ. Энэ улсын төсөв бол их тэлж байгаа, бас улсын төсөв алдагдалтай байгаа. Үүнээс гадна нөгөө муур маань хулганаа барьж байна уу, үгүй юү гээд нэг асуудал байна л даа. Энэ хууль хяналтын байгууллагууд, энэ улсын төсөв тэлж байгаа янз бүрийн энэ олон мега төсөл хэрэгжинэ гэж ярьж байгаа ийм үед бол авлига, хулгай бол цаашидаа гаарна аа, ихэснэ. Тэр бол ойлгомжтой.*

Тэгээд бид нар чинь янз бүрийн үзүүлэлтээр, авлига, хулгайн үзүүлэлтээр бол ямар хэмжээнд байгаа билээ гэдгээ бас мэдэж байгаа. Тэгээд энэ гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах энэ үйл ажиллагаа яг шаардлагын хэмжээнд байна уу. Шүүх засаглал, шүүгч нар маань ямар хэмжээнд байна вэ гэдэг асуудал байгаа юм л даа. 40 тэрбумыг идчихсэн нөхөд 40 саяар торгуулаад л нэг иймэрхүү л байдалтай байгаа. Тэгээд нөгөө хууль, эрх зүйн бодлого явсан, чангарсан гээд бид нар яриад байдаг. Гэтэл яг амьдрал дээр бол эсрэг талаараа л байна л даа. Ингээд энэ дээр бид нарын нэр хүнд их унаж байна аа. Ард түмэн бол яг тэр хуулийг хэрэгжүүлэх, сахиулах энэ үйл ажиллагааг хүсэж байна.

Энэ улсын төсөв ингэж хэлж байгаа юман дээр бид нар нэг юмыг их орхигдуулж байна. Энэ хүний нөөц дээр. Одоо энэ ажил хийж байгаа залуучууд маань ихэнх нь л ажлаас нь гараад явж байна. Яагаад гэвэл цалин пүнлүү нь хүрэлцэхгүй байна, ачаалал нь өндөр байна. Тэгээд энэ Хууль зүйн сайдын төсвийн 24, 25 оны би харьцааг харлаа л даа. Энэ цалин, урамшуулал дээр ерөөсөө л хорьхон хувь л нэмэгдчихсэн байгаа. Тэгээд үнэ ханиш, инфляц энэ бүхэнтэй уялдуулаад харвал энэ чинь юу вэ. Олон жил бид нарын шүүхийг сайжруулна гэж ярьдаг боловч Монгол Улсын хэмжээнд бол стандарт хангасан, олон улсын

стандарт хангасан ганич ч шүүхийн байр байхгүй. Ийм л байлгах хүсэлтэй байна л даа. Тэгээд манай хууль хяналтын байгууллага ч гэсэн хууль сахиулах үйл ажиллагаа тэр тангараг өргөсөн ажлаа бол тийм шаардлагын түвшинд бол хийж, хийдэггүй. Тэр ажлаа хийж байж, энэ татвар төлөгчдийг хамгаалж байж, энэ хувийн хэвшлийнхнийг тэр хуульд заасны хэмжээнд тэр өмч хөрөнгө бүх юмыг нь баталгаажуулж байж, ийм байж байж, та бүхний цалин пүнлүү дээшилнэ ээ.

Олон камер авч тавьсан. Тэрний үр дүн хаана байна. Жил болгон л камераа нэмье гэж ярьдаг. Тэгээд баахан ажиллахгүй камеруудтай байна гэж дараа нь гардаг. Ийм юмнууд байна.

Бас нэг зүйл. Юун цагдаа энхийг сахих үйл ажиллагаанд оролцох вэ. Ийм үүрэг байхгүй шүү дээ. Хууль сахиулах л үүрэгтэй шүү дээ. Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоно гэдэг чинь тэр батлан хамгаалах, тэр цэргийнхний үйл ажиллагаа байхгүй юу. Энэ тусдаа үүрэг зориулалттай. Ийм хаа хамаагүй юманд ингэж оролцож болохгүй л дээ. Үүнийг бас ялгаж, салгаж ойлгох ёстой. Хэрэв тийм байгаа бол тэрийг тэр олон улсын хууль, өөрсдийнхөө хууль номд нь нийцүүлэх хэрэгтэй шүү. Тэрэнд алдаа гараад байна уу, ямар гараад байна. Тэр хүмүүсийнхээ цалин, амьдралыг дээшлүүлэх тэр нь зөв л байдаг байх. Гэхдээ үүрэг зориулалт нь бол буруу тийшээ явж байна аа гэж ойлгох хэрэгтэй.

Хамгийн гол нь тэр хорих байгууллагын хорих хянагч нар, цагдаа нар, жирийн шүүгч нар тийм ээ, тэр хэдийн авдаг цалин пүнлүү ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: *Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.*

Х.Баасанжаргал: *Нэг 2 санал хэлье. Төсөвтэй холбоотой.*

1 дүгээрт, энэ дахиад л давтах гээд байна л даа. Энэ шүүх эрх мэдлийн төсвийн асуудал дээр ер нь нэг иймэрхүү байдалтай, байр суурьтай байхгүй. Цаашид ер нь энэ шүүх эрх мэдлийн бие даасан эдийн засгийн баталгаа л гэсэн үг шүү дээ, энэ чинь эдийн засгийн баталгааны асуудлыг баталгаатай байлгахын тулд Шүүхийн тухай хууль дээр энэ заалт 48.6.3 гэсэн заалт орж ирсэн. Гэхдээ үүнийг юу гэдэг юм, Сангийн яамныхан бид нар салбар салбарын хуулийг ингээд барих юм бол энэ төсөв чинь бүтэхгүй ээ гэдэг байдлаар битгий хандаасай. Дараагийн төсөв дээр ч гэсэн ялгаа байхгүй. Энэ дээр манай хуулийн салбарынхан, шүүхийнхэн ер нь бол нэлээн хатуу байр суурьтай байх ёстой гэж би бол хувьдаа бодож байна. Тэгэхээр энэ дээр ч гэсэндээ энэ удаа ингэж 100 гаруй тэрбум төгрөгөөр хасагдлаа. Яах вэ, ингээд дараагийн удаа ингээд Байнгын хороо ярилцаад ингээд ямар нэгэн байдлаар тодорхой хэмжээгээр нэмлээ гэхэд байнга л ийм байдалтай шүүхийн төсөвт хандах юм бол энэ ерөөсөө бид нарын нөгөө яриад байгаа салбарын эрх мэдлийн хуваарилалтын онолын хувьд энэ чинь асар том алдаа гэсэн үг.

Шүүхийн байрны тухайд Сангийн яамныханд бас тодруулж хэлье л дээ. Тэгэхгүй бол бас мэдээлэлгүй байгаад байдаг юм уу яадаг юм. Банкны байрыг дандаа шилжүүлж өгдөг. Төрийн өмчийн байрны акталсан байрыг шилжүүлж өгдөг. БЗД-ийн шүүхэд та нар өөрсдөө очоод үзээрэй. Сангийн яамныхан. Өөрсдөө болохгүй бол нэг өдөр очиж ажилладаг юм уу, яадаг юм. БЗД-ийн шүүхийг би бол сайн мэдэж байна. Ямар ч тийм хүн ажиллах, удаан хугацаанд тогтвортой байх, ямар ч тийм нөхцөл байхгүй. Хөгцөрсөн, хулгана гүйдэг, тийм байранд хэзээ ч манай энэ яамнууд өөрсдөө байхгүй л байгаа шүү дээ. Бүх яамныхаа байрыг шинэчилчихсэн л байгаа шүү дээ.

Тэгэхээр нөгөө бусад салбартай барьцана гэхээс илүүтэй яг энэ шүүх эрх мэдлийн эдийн засгийн баталгааг яагаад бий болгох гээд байгаа юм бэ гэдэг дээр л, гэдэг талаас нь та бүхнийг бас хараасай гэж бодож байна. Бүр ноцтой жишээ Оросын холбооны өмчийн байранд шүүх үйл ажиллагаа явуулж байна шүү дээ. Энэ болох юм уу. Бүхэл бүтэн тусгаар тогтносон улс орон байж байж. Тэгээд тэр асуудалд ингэж хандмааргүй байна аа л гэдэг утгаар манай энэ Хууль зүйн байнгын хорооныхон нэлээн хатуу байр суурьтай байгаа шүү.

Тэгэхээр дараа дараагийн төсөв дээр ч гэсэн энэ Шүүхийн тухай хуулиа бид нар чанд мөрдөж энэ 48.6-д заасан бууруулахгүй байх гэдэг зарчмыг баримтална аа гэдгийг хэлэх гэсэн юм.

2 дугаарт, 24 оны төсвийн тодотгол дээр цагдаагийн албан хаагчдын цалингийн орон нутгийн нэмэгдлийн тухай нэг яригдаад дурдагдаад өнгөрсөн. Ерөөсөө тухайн үед бол манай цагдаа ерөөсөө орон нутгийн нэмэгдэл авч үзээгүй гэж тухайн үедээ цагдаагийн төлөөлөл орж ирж байсан хүн тайлбарлаж байсан. Тэгээд би бол тухайн үед 25 оны төсөв дээр цагдаагийн албан хаагчдын энэ орон нутгийн нэмэгдлийн асуудлыг оруулж ирээрэй гэхэд бол одоогийн байдлаар байдлаар орж ирсэн ийм зүйл бол алга байна.

Тэгэхээр тухайлаад би бас өөрөө ЦЕГ луу албан тоот явуулъя. Ер нь энэ цагдаагийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой мэдээллийг дээр бас тухайлж дараа дараа жилийн төсөв дээр бас анхаарах ёстой болов уу гэсэн ийм 2 саналтай байна.

Д.Цогтбаатар: Даваагийн Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Дав.Цогтбаатар: Баярлалаа. Бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. ХЗДХ-ийн сайдын багц өнгөрсөн жилийнхээс 430 тэрбумаар өсөж байна. Тэгээд энэ дотор ЦЕГ-ын аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтэс гээд 9 тэрбум, 10 тэрбумаар. Санхүү, аж ахуйн алба гээд 120 тэрбумаар, тэгээд бас энэ өнгөрсөн жилийн захиргаа удирдлагын газрынх нь төсөв жишээлэхэд 5,6 тэрбумаар өсөж байсан байгаа юм. Тэгтэл яг анхан шатын нэгж дээр байгаа цагдаа нарт төсөв гэдэг юм уу хөрөнгө аягүй бага очдог юм байна лээ. Жишээлэхэд, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумд цагдаагийн алба хаагчдад 100 мянган төгрөгийн сарын шатахууных нь мөнгө очдог. Тэр нь юу гэдэг юм, аймгийн төвтэйгөө харьцангуй ойрхон нэг 20 км. Гэхдээ 1, 2 очоод ирээд л нөгөө бензинийх нь мөнгө дуусчаж байгаа юм. Тэгтэл ЦЕГ юу гэдэг юм, төв дээрээ гэдэг юм уу, санхүү, аж ахуйн албан дээрээ гэдэг юм уу мөнгөнүүд нь байгаад байх шиг байна. Тэгэхээр цаашидаа ер нь энэ анхан шатны нэгж, яг энэ фронт дээр үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийнхандаа ядахдаа бензинийх нь мөнгийг, яах вэ, тэр нэмэгдэл энэ тэр нь бусад гишүүд бас хэлээд байх шиг байна. Ажиллах орчин нөхцөлийг нь сайжруулж, юу гэдэг юм энэ тийм өндөр цалинтай алба хаагчид бол бас биш шүү дээ, эд нар чинь. Тэгээд яг өөрсдийнхөө карманаас бензинийхээ мөнгийг гаргаад, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа аймаг руугаа ирж очоод байгаа энэ сумын төвийн цагдаа нар луугаа бас нэг анхаарал хандуулж, энэ их төсөв хөрөнгө дотор нь гүйлгэдэг юм уу, яадаг юм, би бол сайн мэдэхгүй байна. Энэ задаргаанууд нь ирэхгүй байгаа учраас.

Тэгэхээр энэ нь анхан шатныхаа нэгж рүү хандсан яг тэр фронт дээр байгаа хэрэг мөрддөг ч гэдэг юм уу, цагдаагийн нэршлийг бас сайн мэдэхгүй байгаа учраас анхан шатын нэгж дээр байгаа тэр цагдаа нар луугаа энэ төсөв хөрөнгөө яг хүрэлцээтэй бодит байх тал дээр нь бас нэг анхаарч ажиллаарай гэж.

2-т нь болохоор цагдаагийн алба хаагч хийх хүн, өмнө нь Алтангэрэл сайдын ярьж байснаар бол 7500 цагдаагийн орон тоо сул байна гэж ярьж байхыг нь би нэг сонсож байсан, би тоо буруу санаад байж бас магадгүй. Тийм. Тэгтэл цагдаагийн алба хаагчдыг бас маш эрт тэтгэвэрт гаргаад байгаа юм. Тэгэхээр энэ гараад байгаа алба хаагчдаа тэр нөгөө дутуу орон тоон дээрээ цалин мөнгийг нь үргэлжлүүлээд аваад үлдэх боломжийнх нь талаас бас нэг та өөрөө мэргэжлийн хүн байна бас нэг анхаарч ажиллаарай гэсэн нэг ийм 2 үг байна.

Д.Цогтбаатар: Нарантуяа-Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр иргэний зөрчигдсөн эрхээ сэргээх, шүүхээр хамгаалуулах эрхийг төрийн үйлчилгээний нийтлэг хэв шинжтэй хольж, хутгаж тайлбар өгч байгаа нь бол үнэхээр учир дутагдалтай байна гэж харж байна аа, Сангийн яам аа. Тэгэхээр шүүхийн шударга, хэвийн нөхцөлтэй ажиллаж байж энэ бусад бүх салбар, тэгээд нөгөө төрийн үйлчилгээнд шударга ёс төлөвших энэ бүх байдал бол бэхэжнэ гэж би хувьдаа харж байна.

Тэгэхээр иргэн, эрүү, захиргаа гээд нийгмийн бүх салбарт үнэн шударга ёсыг тогтоох газар бол шүүх юм. Тэгэхээр шүүхийг шүүхэд итгэх итгэл нэмэгдэж байж, төрдөө итгэх итгэл нь нэмэгдэнэ гэж би хувьдаа бодоод байна. Тэр битгий хэл, одоо бид нарын энэ хэлэлцэж байгаа, хэлэлцээд батлаад явуулж байгаа энэ төсвийг ч гэсэн хуулийн дагуу зарцуулагдсан байна аа гэдэг шийдвэрийг шүүх л эцэслэн тогтоодог шүү дээ. Тэгэхээр зэрэг нөгөө шүүхийг хараат бус, бие даасан, тийм ээ, хэвийн нөхцөлд ажиллах энэ ажлаар хангахын тулд бас үнэхээр энэ асуудлыг нь бас та бүхэн дахин эргэж харж дэмжээрэй гэж би хүсэж байна.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Төсөв хэлэлцэж байгаа энэ үйл явдалтай холбоотойгоор яг Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дотор би нэг зарчмын хэд хэдэн юмыг яримаар санагдаад байгаа юм.

1 дүгээрт нь, өмнөх төсвүүд болон өмнөх хийж байсан ажлууд ингээд харахаар манай ХЗДХЯ-ны дотоод хэргийн чиг үүрэг дээр бол төсвийн хуваарилалт дийлэнх нь очдог. Барилга байшин тэр чиг үүрэг дээр илүү их нэмэгдэж баригддаг. Тэр чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын төсөв улам бүр данхайгаад байдаг дүр зураг харагдаад байгаа. Тэгсэн мөртөө хууль зүйн чиг үүрэг нь бол сул дорой. Одоо хүртэл, тэрний хамгийн том илэрхийлэл нь 2013 оноос хойш шүүхэд хөрөнгө оруулалт байхгүй. Нэмж хөрөнгө оруулалт ерөөсөө өгөөгүй. Шүүхийн байшин, засвар үйлчилгээ болон стандарт хангасан тэр чиглэлээрээ бол бараг нойл заачихсан ийм байгаад байгаа юм.

Тийм учраас хууль зүйн чиг үүрэгтэй хэсэг дээрээ төсвийг үр ашигтай болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр энэ жил бол амжихгүй боллоо, ирэх жилдээ бас нэлээн анхаарч ажиллаасай гэж би хүсэж байгаа юм. Тухайлбал шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль зүйн чиг үүргийн нэг том хэсэг нь байхгүй юу. Дэлхийн улс орнууд ял эдлүүлэх үйл ажиллагаанаас бусад шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг бол бараг төрийн гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүрэг гэж үзэхгүй байгаа шүү дээ. Ял эдлүүлэх үйл ажиллагаа дотроо дахиад энэ цахим гавтай холбоотой асуудлууд яригдаад эхлэхээр үүнийг бусад татвар төлөгчдийн нуруун дээр бас үүрүүлэх ёсгүй гэж үзэж байгаа. Зөрчил гаргасан, гэмт хэрэг үйлдсэн хүмүүсээр нь энэ зардлыг төлүүлдэг болохоос биш өөр бусад татвар төлөгчдийн мөнгийг энэ чиг үүрэг рүү зарж болохгүй шүү гэдэг

зарчим руу улам бүр яваад байгаа байхгүй юу.

Гэтэл манай шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага юу хийгээд байна вэ гэхээр чиг үүрэг нэмэгдэх, энэ ял эдлүүлэх болон энэ өөр бусад чиг үүрэг дээр яваад ирэхээр энэ төр, хувийн хэвшлийн хамтын үйл ажиллагааг сонирхохоос илүүтэйгээр бид нар нэг ААН шинээр байгуулах юм байна. Бидэнд нэг шинэ чиг үүрэг нэмэгдэж орж ирж байгаа юм байна. Энэтэй холбоотой татвар төлөгчдөөс мөнгө нэмж өгөх ёстой гэдэг буруу хандлага яваад байгаа байхгүй юу.

Тэгээд энийгээ нэг эргэж харах ёстой гэдэг. Ер нь бол шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотойгоор цаашидаа Хууль зүйн байнгын хороон дээр ч гэсэн ял эдлүүлэх болон бусад чиг үүргийг нэг салгаж, 2, 3 эженс болгож авахгүй бол нөгөө даахгүй нохой бялуу хураана гэдэг, булуу хураана гэдэг шиг ингээд өөр өөр дээрээ овоолоод л төсвөө нэмдэг нэг ийм хандлага хэтэрхий газар аваад эхэллээ.

2-т нь, дахиад нэг түрүүн Ганбат гишүүний үгэнд гараад байх шиг байгаа юм. Энхийг сахиулах үйл ажиллагаанд цагдаа орж байна гээд. Яг энхийг сахиулах үйл ажиллагааны чинь хийж байгаа ажлын 90 хувь нь хэв журам сахиулах чиг үүрэг байгаад байгаа юм. Тийм учраас цагдаагийн байгууллага энэ үйл ажиллагаанд НҮБ-ын хүрээнд орох явцдаа шинэ технологи, шинэ арга барилыг хүртэл суралцаж эхэлж байгаа. Тэнд бол шууд дайн байлдааны үйл ажиллагаа руу орохгүй байгаа шүү дээ. Энхийг сахиулах үйл ажиллагааны гол хүрээ чинь зүгээр л иргэддээ аюулгүй байдлыг хангах, хэв журам сахиулах үйл ажиллагаа. Бусад улс орнуудын стандарт ямар байдаг вэ, тэр чиглэлээр суралцаад ирж байгаа байхгүй юу. Энхийг сахиулах үйл ажиллагаанд явсан цагдаагийн албан хаагчид ирээд хамгийн түрүүнд ярьдаг зүйл нь тэнд цэргийн цол хэрэглэдэггүй юм байна шүү дээ. Тэнд

өөр дүрэм журам үйлчилдэг юм байна шүү дээ. Тэнд иргэнтэй харьцах аюулгүй ажиллагаанд ийм стандартууд барьдаг юм байна шүү дээ гээд ирээд дотооддоо өөрчлөлт хийх тийм хүсэл эрмэлзэл бий болоод байгаа.

Тийм учраас энэ үүд хаалгыг зөвхөн батлан хамгаалах юу, тэр чиг үүргийн байгууллагад хийх ёстой гэж хааж ерөөсөө болохгүй шүү. ХЗДХ-ийн сайд энэ дээр анхаараарай. Энэ бол дэлхийгээс шинэ мэдлэг, ур чадвар авахад бас хэрэгцээтэй байгаа нэг үүд хаалга шүү.

3 дахь маш чухал нэг зүйл бол Хууль зүйн сайд энэ шүүх шинжилгээ болон мөрдөх алба, гэрч хохирогчийг хамгаалах гэх мэтчилэн ингээд яг иргэнишсэн, хууль засагладаг, хүний эрхийг хамгаалдаг чиглэл рүүгээ зохион байгуулалт хийхтэй холбоотой тэр төсөв, тэр төсвийн төсөөллөө эртхэнээс тооцож бодохгүй бол орж ирж байгаа төсөв чинь дахиад л дандаа дотоод хэргийн чиг үүрэг рүүгээ орж ирээд байгаа гэдгийг бол анзаараарай. Хууль зүйн яамны хамгийн том чиг үүрэг ч мөн хүний эрхийг хангах, хууль ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Энэ яах вэ, түрүүн асуулт асуусантай холбоотойгоор л энэ бас нэг нэмэлт санал гэх юм уу, тийм ээ, хүсэлт байгаад байгаа юм. Юу гэхээр энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой түрүүн нэлээн төсөв маань нэмэгдэж орж ирсэн, 5 дахин их тийм ээ. Тэгээд юун дээр зарцуулагдах гэж байна аа гээд хариулт авахаар ихэвчлэн л яг л нөгөө нэг Эрүүгийн хууль болон эрүүгийн гэмт хэрэгтэн, ялтантай холбоотой цахим гав, тэр чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой юм байгаа юм. Тэгэхээр сая бас энд хэлж байна. ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын

хүрээнд дотоод хэргийн асуудал нь хэтэрхий данхайгаад байдаг учраас хууль зүйн бодлогын асуудал хаягддаг гэдэг шиг шүүхийн шийдвэр гүйцэтгэл маань өөрөө иргэн, эрүү, захиргаа гэсэн 3 чиг үүргийн тийм ээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хийдэг байгаа. Тэгтэл нөгөө эрүүгийн асуудал дээрээ хэтэрхий данхайгаад, дандаа тийшээгээ анхаарсан зүйлүүдийг хийгээд, яг иргэн, захиргаа ялангуяа иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл маш муудсан. Хуулийн шинэчлэл нь ч гэсэн бас тулгамдаж байгаа. Яг үнэнийг хэлэхэд яг шударга ёсыг тогтоох, өдөр тутмын амьдралд эрх нь зөрчигдөж байгаа ч байдаг юм уу, энэ асуудал дандаа л иргэн болон захиргааны хэргийн шүүхээр шийдвэр гардаг. Тэгээд энэ нь биелэлт байхгүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь энэ дээр дорвитой бас шинэчлэл хийхгүй, бодлогоо төвлөрүүлэхгүй болохоор яг энгийн иргэдийн хувьд эрх нь зөрчигдөөд, тэрийгээ шүүхээр сэргээлгэсэн ч гэсэн тэрийгээ үр шимийг нь хүртэж чадахгүй ийм нөхцөлд байгаа.

Тэгээд энэ нөгөө суурь түвшин болон үйл ажиллагааных нь юуг задаргааг үзсэн ч гэсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэвийн явуулах нөхцөлийг хангана аа гэсэн зорилтын хүрээнд дандаа эрүүтэй холбоотой, хоригдлын хөдөлмөр эрхлэлт, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр гээд эрүүгийн асуудалтай холбоотой л шүүхийн шийдвэр гүйцэтгэлүүдийн зорилтуудыг оруулсан байгаа юм.

Тэгэхээр Хууль зүйн сайдад хүсэж байгаа нь одоо энэ захиргаа болон иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуулиа хурдан өргөн бариад, энэ гүйцэтгэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиг үүргүүдээ илүү оновчтой болгоод, ялангуяа иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг эрүүгээсээ салгаад, харьяалах ёстой харьяалах байгууллагад нь тийм ээ, иргэнийх бараг шүүхийн доороо ч байдаг юм уу, дараа нь энэ хяналт гүйцэтгэл нь ямар байна гэдгийг

хянах механизмтай ийм байдлаар оруулж ирэхгүй бол иргэд, ААН-үүдийн эрх хохирсоор байна. Тэгээд шүүхэд итгэх итгэл нөгөө л 10 жил, 5 жил яваад ирсэн шүүхийн шийдвэр маань угаасаа гүйцэтгэл дээр очоод гацдаг, бүр байхгүй болдог гэсэн энэ рүү л яваад байгаа учраас энэ дээр та бас анхаарч, дараа дараагийн хууль зүйн бодлогоо энэ дээрээ тодорхойлж, ийшээ чиглэсэн хөрөнгө оруулалт, ийшээ чиглэсэн бодлогын үйл ажиллагаанууд дээрээ анхаараасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Зарчмын зөрөөтэй санал байгаа. Зарчмын зөрөөтэй 2 санал байж байгаа. Үүнийг Байнгын хорооны даргын хувьд би гаргаж байгаа юм. Манай Байнгын хорооны гишүүд ч сая, би гаргаж байгаа гэдэгтээ биш шүү, нөгөө аль нэг гишүүн гаргах ёстой учраас би Байнгын хорооны гишүүний хувьд энэ саналыг гаргаж байгаа. Манай Байнгын хорооны гишүүд их олон гишүүн нь хэллээ. Энэ юутай холбогдуулаад, зарчмын зөрөөтэй энэ санал үнэхээр гаргахаас өөр юу сонголт байхгүй. Яагаад гэвэл хууль маань тийм байгаа юм.

Тэгээд байнгын хороо бол өөрийнхөө хуулийг барина.

Эхний санал 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Төслийн 2 дугаар хавсралтад ШЕЗ-ийн шүүхийн байрууд, улсын хэмжээнд, төсөвт өртөг 61 тэрбум 600 сая төгрөг, санхүүжих дүнг 61 тэрбум 600 сая төгрөг, ШЕЗ-ийн тоног төхөөрөмж, улсын хэмжээнд, төсөвт өртөг 10 тэрбум 383 сая 700 мянган төгрөг, санхүүжих дүнг 10 тэрбум 383 сая 700 мянган төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг тус тус нэмэх. Нийт 71 тэрбум 900 сая төгрөгийн эх үүсвэрийг доор

дурдсан төсөл, арга хэмжээний дүнг бууруулах замаар гаргах. Үүнд:

1. 4.1.4.1-д тусгагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ бэлтгэх, бэлтгэл хангалт төсөвт өртөг болон 2025 онд санхүүжих дүн 40 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах,

2. 10.2.1.2 дахь заалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах төсөвт өртөг 11 тэрбум, 2025 оны санхүүжих дүн 11 тэрбум гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах,

3. 10.1.3.2 дахь заалтын гаалийн хяналтын тоног төхөөрөм, улсын хэмжээнд, төсөвт өртөг 12 тэрбум 900 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 12 тэрбум 900 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах,

4. 10.3.3.1 дэх заалтын татварын байгууллагын байгууллагуудын тоног төхөөрөмж, улсын хэмжээнд, төсөвт өртөг 8 тэрбум төгрөг, 2025 онд санхүүжих дүн 8 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах гэсэн ийм зарчмын зөрөөтэй санал оруулж байна.

Тэгээд энэ дээрээ би юу дэгийн хуулийн дагуу тайлбар хийх эрхтэй. Тийм учраас би санал гаргаж байгаа гишүүний хувьд бол тайлбар хэлмээр байна.

Сангийн яаманд хандаж оруулж ирж байгаа төсөв та нарын ярьж байгаа тайлбар бид нар ойлгож байгаа. Гэхдээ Сангийн сайд аа, нэг зүйлийг үнэхээр энэ дээр ярихгүй бол болохгүй байна аа. Энэ чинь та бол ингээд нөгөө төсвөө ярихаар өөрийнхөө Төсвийн хуулийг яриад байгаа юм. Тэгтэл Монгол Улсын бусад хуулиуд чинь хэрэв төсвийн асуудал хэлэлцэж байгаа бол тэр төсвийн хуулийн чинь нэг хэсэг байхгүй юу. Түүнээс төсвийн хууль гээд ганцхан төсвийн хууль заачаад төсөв

зохицуулсан өөр хууль байгаад байхад танд ч юм уу, надад ч юм уу, үүнийг сонгож, энэ нь бол хууль юм, энэ нь хууль биш юм шиг үлдээх эрхийг хууль бидэнд олгоогүй ээ.

Тэгэхээр энэ Шүүхийн тухай хуулийн би танд, одоо энд, Сангийн яамныхандаа, цаашидаа та нар төсвөө боловсруулаад сайддаа энэ юмаа оруулж өгөхдөө үүнийг хэрэгжүүлж байх ёстой байгаа юм аа. Юу гэвэл 48.46.8 дээр ингээд заачихсан байгаа шүү дээ. Улсын Дээд шүүх, Ерөнхий зөвлөл Улсын Дээд шүүхээс бус бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн, төсвийг гэж байгаа биз. Энэ төсвийг зохицуулж байгаа хууль байхгүй юу. Төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлнэ ээ.

Ингээд цаашаа явж байгаад 46.8.3 дээр Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр төсвийг яриад байгаа биз, бас. Өөр үг хэрэглээгүй байхгүй юу. Яг төсвийг ярьж байгаа. Энэ төсвийг зохицуулж байгаа юм. Шүүхийн асуудал дээрээ. Төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн барина аа гээд ингээд заачихсан.

Тэгээд энэ чинь аливаа хуулийг тайлбарлахдаа Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж байгаа бүх хуулиудын нийлбэр дүн, харилцан үйлчлэлээс л хуулийг тайлбарлана. Тэгэхээр энэ бол ингээд хөдөлгөөнгүй хууль байгаа учраас Хууль зүйн байнгын хороо өөрийнхөө баталсан 1 дүгээрт, тогтоол, тэгээд энэ хуулиа бол даган мөрдөхөөс өөр аргагүй ээ.

Энэ дээр би бас нэг зүйлийг хэлмээр байна. Жишээлбэл түгжрэлийн асуудал ч юм уу, 14 том төсөл энээ тэрээ бид нар энэ рүү халдахгүй байгаа. Үүнийг чинь хүндэтгэж үзэж байгаа. 20 минутын хотыг хүндэтгэж үзэж

байгаа. Над дээр анх ингээд санал оруулаад ирж байхад зөндөө саналууд орж ирсэн. Энэ жишээлбэл том төсөлтэй холбоотой ч юм уу, 20 минуттай холбоотой тэр төслүүдтэй холбоотой төсөл юу төсвөөс хасаагүй шүү.

Энэ дээр нэг зүйлийг онцолж хэлмээр байгаа юм. Үндсэн хуулиа бид нар барих ёстой. Үндсэн хууль дээр чинь ерөөсөө 3 дугаар бүлэг дээр төрийн байгуулалт гэдэг хэсэг дээр нь засаг, хууль тогтоох байгууллага, шүүх гээд, ерөөсөө төрийн өнөөдрийн оршин тогтнох 3 багана чинь энэ. Тэгж яривал энэ 23 сайд чинь бүгдээрээ байх шаардлагагүй. Үндсэн хууль дээр байхгүй шүү. Харин шүүх бол байгаа. Шүүхийг заавал тэр санхүүжилтийг нь олгох ёстой. Тэр 23 сайдаасаа тэгвэл 9 болгоод, 10 болгоод, үлдсэнээс нь гарсан мөнгийг энэ рүү тавьж болно шүү дээ. Ингээд ярих юм бол энэ дээр чинь улс төрийн талаасаа ч гэсэн асуудал яригдаж байгаа байхгүй юу. Бид нар хэмнэлт яриад байгаа бол энд хэмнэлт гэж ярьчихаад, энд дэлхийд байхгүй олон тооны сайдын тухай асуудал яригдаад байна шүү дээ.

Тийм учраас энэ дээр бол үүнийг бид нар манай Байнгын хороо бол өөрийнхөө байр суурин дээр хатуу байх болно гэж би найдаж байна. Гишүүддээ тэгээд ийм зарчмын зөрөөтэй саналыг оруулж байна. Тэгээд дэмжиж өгөхийг бас хүсэж байна.

Тайлбар, дэгээрээ байхгүй шүү дээ. Яг үнэн, яг үнэн юу Сангийн сайд аа. Тэгвэл наад та тайлбараа өгчих. Би энэ дээр нь бас тайлбар хийе.

5 дугаар микрофон.

Б.Жавхлан: Баярлалаа. Тайлбар хийх боломж өгч байгаад. Түрүүн Энхбаяр гишүүн, Тэмүүжин гишүүд их тодорхой хэлсэн дээ. Энэ жилдээ яах вэ, ингээд Засгийн газраас оруулж ирж

байгаа энэ чинь үндэсний хэмжээний л 4 жилийн бид нарын хөгжлийн хөтөлбөртөө тохируулж томоохон бүтээн байгуулалт ялангуяа дэд бүтцүүдээ оруулж ирж байгаа шүү дээ. Салбар салбарын асуудлуудыг ингээд төсвийн ерөнхийлөн захирагч нар бүгдээрээ нэг жил ингээд нэг тэвчье ээ. Тэгээд 26 оноос эхлээд бүтээн байгуулалтуудаа салбар салбарын энэ шаардлага тулчихсан ажлуудаа хэвийн үргэлжлүүлээд явна шүү дээ. Тэгж байхад ингээд заавал тэрийг ингээж сэтэлж хаяад, одоо энэ чинь бол цаашаа бүгд рүү нь л урсана. 1-д.

2-т, таны яг тэр онилсон байгаа тэр хөрөнгө оруулалтууд чинь жоохон харамсалтай л байна. Жишээ нь тэр Эдийн засгийн хөгжлийн яаман дээр байгаа ТЭЗҮ, бүтээн байгуулалтын тэр төлөвлөлтийн гол мөнгө шүү дээ, тэр 40 тэрбум төгрөг чинь. Өөрөөр хэлбэл 26 онд хийгдэх төсвийн хөрөнгө оруулалтуудын бэлтгэл ажил, ТЭЗҮ, зураг төсвийг энэ мөнгөөр 25 онд багтааж хийдэг ийм л зүйл юм байгаа юм. Тэрийг бүр ингээд тэг үлдэгдэлтэй болгоод хаячихаар бид нар 26, 27, 28 онуудад юу ч хийж чадахгүй, бидэнд ямар ч шинэ зураг, төсөв байхгүй болж байна аа л гэсэн үг. Тэгээд энэ юмнуудаа бас нэг аль аль талаас нь хараасай л гэж хэлэх гэсэн юм. Тийм.

Д.Цогтбаатар: Сангийн сайд аа, яг өөрийн чинь ярьж байгаа тэр зураг, төсвийн асуудал, бид хуулиа нөгөө барина гэж байгаа, би хууль л ярина. Тэгэхээр энэ дээр ийм асуудал байгаа байхгүй юу. Бид нар 100 тэрбумын төсөв оруулж ирэхэд нээрээ бас яг зураг, төсөвгүй хэсгүүд байна лээ. Тэрийг нь хасчихсан байхгүй юу. Яагаад гэвэл энд хуулиар батлагдсан ч тэнд зураг, төсөв байх ёстой гэдэг бол шүүхийн байгууллагад ч хамаарч байгаа учраас тэр дээр нь бол хасалтуудыг нь хийж өгөөд оруулж ирж байгаа юм. Бусад зураг, төсөвтэй тэр асуудлууд чинь яам болгон дээрээ өөрийн тусдаа төсвүүд

суугдчихсан байж байгаа шүү дээ. Тийм. Тийм учраас тэрийгээ та нар бариад өөрсдөө зохицуулаад л явах ёстой. Тийм.

Саяын ингээж, уншиж танилцуулсан зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор.

66,7 хувиар саяын санал дэмжигдлээ.

Тэгээд Сангийн сайд өөрөө энэ дээрээ нөөц бололцоогоо ажлын хэсэг дээрээ та нар ажиллаад явна биз. Манайх бол энэ дээр ингээд байр сууриа гаргаж байна.

Зарчмын зөрөөтэй 2 дахь саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын 24.1.1 дэх хэсгийн Улсын дээд шүүхийн цахим систем, Улаанбаатар Чингэлтэй дүүрэг, төсөл, арга хэмжээнд тусгагдсан 2 тэрбум 493 сая төгрөгийн зардлаас 1 тэрбум 919 сая төгрөгийг хасаж, 24.3.1 нэгдэх хэсгийн Улсын дээд шүүхийн тоног төхөөрөмж, 2 тэрбум 942 сая Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, төсөл, арга хэмжээний зардал дээр нэмж, 4 тэрбум 850 сая төгрөг болгох гэсэн ийм томъёололтой юу, тийм, энэ бол ямар нэгэн дүн нэмэгдэж, хасагдаагүй. Яг дотроо энэ төсөв дотроо хуваарилалт хийж байгаа шүү. Тийм энэ бол яг өөрсдийнх нь асуудал байгаа юм. Тийм.

Ганбат гишүүнд асуулт өгье, микрофоныг нь өгье.

Д.Ганбат: Санал гаргаж байгаа гишүүнээс асууя аа, та юм байна тийм ээ. Энэ юун Улсын дээд шүүх болоод явчхав аа. Хаанахын ямар юмнаас нь хасаад байна аа. Тэр Улсын дээд шүүх нь тийм их мөнгө төгрөг хэрэгтэй газар юм уу? Тэр анхан шатныхаа шүүх, тэр юман дээр л анхаараач гээд би яриад байгаа юм. Тэр Улсын дээд шүүхийн тэр лоббид

нь ороод байдаг юм уу, яадаг юм, яг ямар учиртай юм. Би нэг бас тайлбарыг нь сонсчихъя. Шүүхийг бол дэмжиж байна, шүүгч нарыг бол дэмжиж байна. Гэхдээ шүүх шүүгчдийг бол ажлаа хийх, сайн хийлгүүлэх шаардлагатай байна. Тэрийг л яриад байгаа юм л даа. Наад захын юмнуудыг нь хангаж өгөх хэрэгтэй байна. Тэгсэн чинь юу вэ, нэг гэнэтхэн л Улсын Дээд шүүх яриад унах чинь.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүн ээ, энэ ингэсэн юм аа. 2024 оны 10 дугаар сарын 18-нд манай Байнгын хороон дээр ийм хүсэлт орж ирээд, энэ Сангийн яамнаас юу санал болгож байгаа төсөв. Энд юу ч, дүнг нь хаашаа ч өөрчлөөгүй. Энэ дотроо Дээд шүүх өөрөө хаана хаанаа яаж хуваарилах вэ. Энэ хүсэлтээ өөрсдөө гаргасан. Энд ямар ч тийм зөрчилтэй юм, мөнгө нэмж байгаа, хасаж байгаа юу ч байхгүй. Өөрсдөд нь оногдсон мөнгөө л харин энэ чинь нөгөө төсвийн хууль болохоор нэг батлагдаад гарчихвал хууль болчихно. Өөр тийшээ зарцуулж болохгүй болчихож байгаа байхгүй юу. Тийм, үгүй ээ, тэгэхдээ өөрсдийнх нь хуваарилаад өгч байгаа төсвөө өөрсдөө дотроо зөв зохистой хуваарилалтаа л өөрсдөө хийж байг. Тэд нар илүү мэднэ шүү дээ, Ганбат гишүүн ээ, би лав энд бас мэдэхгүй яг үнэнийг хэлье. Үгүй ээ, үгүй наадах чинь тэгэхгүй бол бид нар хууль болгоод гаргаад өгчихнө. Өөрсдөд нь зориулалтын яг, өөрсдийнхөө хэрэгцээг сайн мэдэж байгаа шүү дээ, тийм. Тэгэхгүй бол болохгүй шүү дээ, бид нар өөр юман дээр батлаад өгчихнө.

Улсын дээд шүүхийнхэн алив байна уу? Наад энийгээ өөрсдөө тайлбарла даа? Тийм. 2 дугаар микрофон. Улсын дээд шүүхээс та нар өөрсдөө суугаад энэ тайлбараа хий. 2 дугаар микрофон.

С.Заяадэлгэр: Улсын дээд шүүх нь, шүүх өөрөө Шүүхийн юу, дээд шүүхийн ерөнхий шүүгчийн багц гээд нийт шүүхээсээ тусдаа төсөвтэй явдаг.

Улсын дээд шүүхийн дэргэд Шүүхийн академи бас хамт энэ Дээд шүүхийн төсөв дотор хамт орж явдаг. Энэ нь өөрөө академи нь өөрөө нийт бүр 600 шүүгчтэй сургалт явуулдаг ийм байгууллага байгаа. Тэгээд энэтэй холбоотой манай байгууллагын төсөв байгаа.

6 дугаар сард Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, шүүхийн ил тод байдлыг хангах цахимжилт дээр хуульд өөрчлөлт орчихсон. Энэ дагуу нь нөгөө Улсын дээд шүүх дээр хамаарах, холбогдох төсвийн өөрчлөлт байгаад байгаа юм. Энэ шүүхийн цахим систем гэдэг хөрөнгө оруулалтынхаа дотор, задаргаа дотроо цахим системдээ зарцуулах мөнгөө тоног төхөөрөмж, шууд дамжуулалтын тоног төхөөрөмж жишээлбэл шүүх хуралдааны шууд цахим хурал хийхэд, хэргийн оролцогчид цахимаар оролцохтой холбоотой гэх мэт тоног төхөөрөмжийн зардлаа дотор нь гүйлгээж байгаа юм.

Хавар Байнгын хороогоор хянагдаад Сангийн яаманд хүргүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтынхаа хэмжээ дотроо ангилал өөрчилж байгаа. Тийм. Одоо софтверт зориулах мөнгөө л хардвэр лүүгээ шилжүүлж байгаа гэсэн үг. Тийм. Дээд шүүхийн шүүх хуралдаан бол шууд цацагдана.

Д.Цогтбаатар: Одоо жишээлбэл энэ ярьж байгаа юм нь бид нар нөгөө батлаад өгсөн шүүхийг ил тод болгох, одоо энийгээ л ажил хэрэг болгох гээд л тэгээд 1 ч төгрөг нэмсэнгүй шүү дээ, тийм.

Тэгээд саяын уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

73,3 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн асуудал хэлэлцэхэд оролцсон ажлын хэсгийнхэнд бүгдэд нь баярлалаа. Сангийн яаманд баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Ингээд санал хураалт явуулж дууслаа. Төсвийн төслийн тухай 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

13.03 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

“Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай” Хууль зүйн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ингээд энэтэй холбогдуулан нам, эвслийн бас удирдлагууд хоорондоо энэ асуудлыг хэлэлцэж ярилцаад, энэ Хүний эрхийн дэд хорооны даргад нэр дэвшүүлэх хүнийг бол Эрдэнэболд гишүүнийг гэсэн ийм санал өгсөн байгаа.

Тэгээд би энэ Эрдэнэболд гишүүнийг Хүний эрхийн дэд хорооны даргад нэр дэвшүүлэх саналыг оруулж байна.

Ингээд нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Тэгвэл нэр дэвшигчдээ. Цогтбаатар гишүүн үү? Цогтбаатар

гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Дав.Цогтбаатар: Нэр дэвшиж байгаа Эрдэнэболд гишүүнээс асуух асуулт байна. Хүний эрхийн дэд хороог ахалсан тохиолдолд ажлаа юунаас нь эхлэх вэ? Тэгээд Хүний эрхийн дэд хороог ахлах бол эрх зүйт төрийн талаарх таны ерөнхий байр суурь, итгэл үнэмшлийн талаарх өөрийнх нь байр суурийг сонсьё.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Он гараад бид нар Үндсэн хуулийн, шинэ Үндсэн хуулийн 33 жилийнхээ ойг угтаж байгаа. Сүүлийн 30 жилийн хугацаанд хүний эрх, эрх чөлөөний талаар Монголчууд бас зохих ёсны ойлголттой болсон. 2000 онд буюу 24 жилийн өмнө хүний эрхийн комисс байгуулагдаж, сүүлийн 24 жилийн хугацаанд бас үйл ажиллагаагаа явуулж байгаа. Тэгээд номер нэг асуудал бол мэдээж Үндсэн хуулийг бэхжүүлэх, Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг дээр байгаа хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой ажлыг Улсын Их Хурал илүү үр бүтээмжтэй, илүү сайн үр дүнтэй явуулахад Хууль зүйн байнгын хорооны дэргэдэх Хүний эрхийн дэд хороо бол ажиллах ёстой гэж бодож байгаа.

2 дугаарт, ХЭҮК болон бусад судалгааны байгууллагууд, мөн олон улсын Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа байгууллагуудтай бид нар нягт хамтран ажиллах ёстой байх. Манай улсын Засгийн газар сая 24 оноос 28 онд хэрэгжих 4 жилийнхээ мөрийн хөтөлбөртөө энэ хүний эрхийг, хүний эрхийн индексийг бас ахиулах ийм зорилгуудыг тавьсан байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын үндсэн чиг үүрэг бол мэдээж энэ хүний эрхийн салбарт парламентад ёсыг бэхжүүлэх, энэ утгаараа бас хүний эрх энэ салбарт томоохон өөрчлөлтүүдийг хийх байх аа гэж зорилго тавьж байгаа. Энэ дээр яг

хэрэгжилт дээр нь манай Хууль зүйн байнгын хороо, тэр дотроо бас Хүний эрхийн дэд хороо маш сайн, санаачилгатай, итгэл үнэмшилтэй ажиллах нь зөв байх аа гэж бодож байгаа.

Энэ дээр бас Хүний эрхийн дэд хорооны гишүүд болон Хууль зүйн байнгын хороо болон бусад Улсын Их Хурлын гишүүдтэйгээ хамтран ажиллана аа гэж бодож байна. Баярлалаа.

Эрх зүйт нийгмийн үзэл санаа гэж байгаа. Ер нь бид Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.4 дээр байгаа Монгол Улсын тусгаар тогтнолын гол баталгаа бол энэ эрх зүйт төр нь өөрөө хүний эрхийг хамгаалсан ардчилсан тогтолцоо гэж бид нар тодорхойлсон байгаа.

Тэгэхээр энэ зарчмын төлөө бид явах ёстой. Энэ зарчмыг бид хэлбэрэлтгүй хэрэгжүүлж, парламентат ёсыг бэхжүүлэх, хуулийг дээдлэх, шударга ёсыг сахиулах энэ чиглэл дээр Хүний эрхийн дэд хороо маш сайн ажиллах ёстой гэж харж байгаа.

Д.Цогтбаатар: Ингээд нэр дэвшигчдэдээ бас нэр дэвшиж байгаа энэ асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Нара гишүүнээр тасаллаа. Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Нэр дэвшиж байгаа хүний хувьд бол хүний эрхийн мэдрэмжтэй ажиллах байх аа гэж итгэж байна. Гэхдээ энэ хүний эрхийн асуудал ер нь та нар бодоод үз дээ. Бид нар ингээд дэд хороо, одоо манай парламент бол хүн төвтэй парламент байна аа гээд хүн бол манай парламентын гол зорилгын хамгийн тэргүүний тийм ээ, орой дээрх ингээд гурвалжингаар бодвол орой дээрх асуудал гэж ингээд томъёолчихсон байж байна шүү дээ. Гэтэл бид нар хүний эрхийн асуудлыг, хүний эрхийн асуудлыг

дэд асуудал болгоод, Хууль зүйн байнгын хорооныхоо салбар хороо болгоод, тэрэндээ миний бодлоор бол хүний эрхийн асуудал бол тэргүүн асуудал байх ёстой байхгүй юу. Гэтэл ингээд Хууль зүйн байнгын хорооны нэг салбар хорооны дэд ингээд хороо болоод, тэгээд тэрнийхээ даргыг гэж байхаар ингээд энэ нөгөө нэг логик авцалдаа хаана байна аа гэдэг дээр би жоохон гайхаад байгаа байхгүй юу. Угтаа бол бараг хүний эрхийн асуудлыг хариуцсан тусдаа ийм Байнгын хороо байгаад, тэгээд тэрнийхээ юуг яагаад тэр чинь жинхэнээсээ парламентын нөгөө гол зорилт бүхий хүн төвтэй гэдэг асуудлыг чинь юу болох юм биш үү гэж бодоод байх юм. Та бүхэн энэ дээр юу гэж бодож байна аа? Би буруу бодоод байгаа юм болов уу, эсвэл.

Д.Цогтбаатар: Нараа гишүүн, юу ингэе. Би өөрийнхөө энэ дээр тайлбар хариултыг өгөөд тэгээд бас би Энхбаяр гишүүнийг энэ дээр Хүний эрхийн дэд хорооны бас дарга байсан хүний хувьд ганц 2 тайлбар хэлэх болов уу гэж бодож байна.

Ийм дэд хороо гээд асуудлыг жижгэрүүлж байгаа юм огтоос биш. Яагаад гэвэл бид нар угаасаа жижгэрүүлж болохгүй. Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг тэр чигтээ ерөөсөө энэ сүүлийн 30 жил бид нарын дагаж ирж мөрдөж ирсэн Үндсэн хуулийн хамгийн гол хэсэг нь дандаа хүн байсан. Ерөөсөө. Тэгэхээр энэ дэд хороо байсан, байгаагүй Үндсэн хууль өөрөө утга агуулга нь хүний төлөө оршиж байгаа төр. Тэгээд Үндсэн хуулиараа заагаад өгчихсөн байгаа. Өөр ямар ч хуульд үүнийг оруулж заагаад хэрэггүй. Яагаад гэвэл Монголын ард түмний хамгийн бодит хүсэл эрмэлзлийн тэр төлөөлсөн бичиг чинь өөрөө Үндсэн хууль байхгүй юу. Тэгээд түүн дээрээ үүнийг маш тодорхой заагаад өгчихсөн Үндсэн хуулийн заалт байхгүй. Юун дэд хороо.

Тийм учраас манай энэ, жишээлбэл Хууль зүйн байнгын хороо эд нар чинь тэр чигээрээ хүний эрхийн төлөө л явж байгаа юм. Бид нар тэрийг хэлээгүй байхдаа ч хууль хүний эрхийн төлөө л ажиллаад байгаа юм. Тийм учраас энэ дээр харин бүр тодотгож, манай энэ Хууль зүйн байнгын хороо дээр нэмээд Хүний эрхийн дэд хороо, түүнээс хуулийн асуудал болгоноор дэд хороо байгуулаагүй байгаа биз. Ганцхан хүний эрхийн асуудлаар л дэд хороо байгуулна гэдэг чинь хууль хуулиуд дотроосоо ганцхан асуудлыг сөхөж л, энэ дээр тавьж байгаа байхгүй юу. Энэ бол тэгэхээр маш өндөр ач холбогдол өгч байгаагийн угаасаа илрэл.

Тэгээд манай Их Хурал дээр бол дандаа хүн төвтэй, хүний эрхийн асуудал голлон яригдаад явдаг болчихсон нь бас бид нар ингээд практик үйл ажиллагаагаараа Үндсэн хуулийн энэ заалтууд чинь тунхаг биш бодит ингээд хэрэгжээд явж байгаа гэдгийн л илэрхийлэл байгаа юм.

Тэгээд Энхбаяр гишүүн бас ганц 2 үг хэлье гэсэн үү? Яг энэ дээр. Энхбаяр гишүүний микрофоныг өгье

Б.Энхбаяр: Эрдэнэболд гишүүнийг дэмжиж байгаа. Тэгээд ер нь бол яах вэ. Протоколд бас нэг үлдээгээд бас Байнгын хорооны дарга бас даргын зөвлөл дээр бид нар чинь нөгөө парламент өөрөө дэгээ тогтоодог. Тэгээд шинэ тутам байгуулагдсан 126 гишүүнтэй парламентын дэг хийж байхдаа нэг зүгээр одоо бид нар анзаарч байхад тухайн салбарынхаа сайдыг бас Байнгын хорооноосоо гаргачихдаг нь их буруу юм болсон байна. Тэгээд жишээлбэл, Хууль зүйн байнгын хороо гэхэд Хууль зүйн сайдгүйгээр хууль зүйн бодлого ярина гэж бол байхгүй байгаад байгаа юм. Би бол жишээлбэл 2 Байнгын хороонд харьяалагдаж байна л даа. Хууль зүйн болон Аюулгүй байдлын байнгын хороонд. Тэгэнгүүт Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд

Гадаад хэргийн сайд байхгүй бид нар гадаад бодлого яриад байгаа байхгүй юу. Тэгээд энэ нь ерөөсөө болохгүй юм байна лээ. Бид бусад улс орны тэр турилага судалж байх үед бол яах вэ, өөрийнхөө зарцуулах гэж байгаа сая бид төсвийг батлах дээр л кноп дарахгүй гэж ойлгосон. Ойлгож ухаандаа энэ бол сонирхлын зөрчил байж болох юм аа гэж үзсэн байхгүй юу.

Тэгэхээр тухайн салбарын сайд нь яг кноп дарах саналын эрхгүйгээр Байнгын хорооны гишүүн байдаг, явахгүй бол энэ нөгөө парламент болон гүйцэтгэх эрх мэдэл Засгийн газар бас алсрах, хүний сэгдүү болох ийм үр дагавар бас байна. Тийм. Жишээлбэл манай Хууль зүйн сайд гэхэд нөгөө Хууль зүйн байнгын хорооны ядаж зар ч ирэхгүй, хэлэлцэж байгаа асуудал очихгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ парламент дээрээ нөгөө Байнгын хороо нь юу хэлэлцээд байгааг сайд маань мэддэггүй. Бид болохоор сайдгүйгээр салбарын хууль тогтоомж, бодлого яриад байдаг. Тэгэхээр энэ чинь өөрөө энэ дотор алдаа, эндэгдэл гаргах, мэдээллийн урсгал дээр асуудал үүсгэхээс эхлүүлээд энэ цаашидаа асуудал үүсгэх тийм нигуур харагдаад байна л даа.

Тийм учраас энэ намрын чуулганаараа энэ ганц үгтэй хуулиа яг ийм агуулгаар нь Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо 2 санаачлаад нэг залруулчихмаар юм шиг санагдаад байгаа юм. Үүнийг л протоколд үлдээх гэсэн юм.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье. Тэгэхдээ хэдүүлээ юугаа барина шүү. Би түрүүн үг хэлэх боломж олгочиход, 2 гишүүн хэлэхгүй байж байснаа хэлье гэж байна. Тэгэхдээ хэлье, хэлье. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Нараа гишүүний асууж байгаа асуулт бол их чухал асуулт байгаа юм. Уул нь бол парламентын бүх Байнгын хороо иргэний эрх, эрх чөлөөг

хамгаалахад, хангахад зориулагдаж байгаа. Эдийн засгийн байнгын хороо бол эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой, эрхтэй холбоотой асуудлуудыг ярьдаг. Хууль зүйн байнгын хороо бол нөгөө жастис гэж яриад байгаа шударга ёстой, маргаан ишидвэрлэх үйл ажиллагаатай холбоотой асуудал дээр нь илүү төвлөрдөг гэх мэтчилэн. Тэгээд зүгээр, яг Нараа гишүүний нэг ярьж байгаа өнцөгтэй холбоотой түүх. Би гаднын парламентаар оччихоод Хүний эрхийн дэд хороотой. Би тэгэхээр Хүний эрхийн дэд хорооны дарга байсан юм. Хүний эрхийн дэд хороотой нь уулзмаар байна аа гээд хүсэлт тавьсан чинь гайхаж харж байснаа би бол өөрийнхөөрөө төсөөлөөд, Хууль зүйн байнгын хорооны харьяа эрхэлж байгаа Хүний эрхийн дэд хороотой уулзаж болох уу гэдэг асуулт тавьсан чинь ийм Хууль зүйн байнгын хороонд ийм дэд хороо бол байхгүй шүү дээ. Яг таны асууж байгаа хороо бол Гадаад бодлогын байнгын хороон дээр байгаа шүү дээ. Хүний эрх гэдэг ойлголт өөрөө энэ улсын иргэдийн эрхийн асуудал биш учраас министр оф жастис буюу эс үгүй бол Дотоод хэргийн яам бол энэ чиглэлийн юмыг хийдэггүй шүү дээ гэж хэлж байгаа байхгүй юу.

Монгол Улсын Үндсэн хууль яг тийм юм байна лээ, бас. Тэр улсуудтай адилхан. Монгол Улсын Үндсэн хууль дээр юу гэж хэлсэн гэхээр Монгол Улсын заавал эдлэх зайлигүй эдлэх иргэний үндсэн эрх, эрх чөлөө гэж ойлголт байгаа. Иргэний үндсэн эрх, эрх чөлөө. Хүний эрхийн тухай ярих юм бол тэр улсын харьяалж байгаа иргэн болон эс үгүй бол харьяалалгүй хүнтэй тэр улстай нь ижил хэмжээний юу бодлого явуулна аа гэж байгаа юм. Манай улсын иргэний эрх, эрх чөлөөг хүндлээд зөвшөөрч байгаа бол би танай улсын иргэний эрх, эрх чөлөөг энэ нутаг дэвсгэр дээр адилхан хүлээн зөвшөөрнө шүү гэдэг. Ийм гадаад бодлогын зарчим Үндсэн хууль дээр бичигдсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд энэ дотор Хүний эрхийн дэд хороо гэхээсээ илүүтэйгээр энэ иргэний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтынх нь дэд хороонууд байх ёстой юм байна лээ. Жишээ нь Киргиз бол манайхаас түрүүлээд явчихсан байсан юм. Тэр үед. Бас би нөгөө Киргизийнхэнтэй уулзсан чинь. Манайд бол Хууль зүйн болон Дотоод хэргийн чиг үүрэг бүхий яамны агентлагуудаар хяналтын хороонууд байдаг шүү дээ. Цагдаа бол цагдаагийнх, тэр бол тэрнийх гээд. Тэгснээс биш ийм ерөнхий нэртэй хороо бол байхгүй. Парламентын өөрийнх нь хийх үндсэн ажил нь энэ шүү дээ. Нэг дэд хороон дээр ачаалж, энэ нэрийг авч болохгүй шүү дээ гэдэг тийм үгийг хэлж байсан.

Тэгэхээр бид цаашидаа нөгөө парламентын зохион байгуулалтыг сайжруулах, дэгийг сайжруулах, чиг үүргийг оновчтой болгох чиглэлээрээ өөрчлөлт, шинэчлэлт хийхдээ бас энэ тухай бол бодож эргэцүүлэх ёстой юм байна лээ. Хүний эрхийн дэд хороо гэж байна уу гэвэл бол Гадаад бодлогын байнгын хороон дээр ийм дэд хороо, өөр бусад улсын иргэн Монгол Улсад ямар хэмжээний эрх, статустай байх тухай бол ярьж болж байна. Яг дотоод хэргийн болон хууль зүйн чиг үүрэг бүхий энэ байгууллагуудын хүрээнд бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөтэй холбоотой хэсэг бүрэн хангагдаж байна уу, үгүй юу, хууль тогтоомж нь боловсронгуй болж байна уу, үгүй юу, энэ чиг үүрэг бүхий хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагууд нь зөв зохион байгуулалттай байна уу, үгүй юу, иргэний байж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр илүү анхаарч, ажилладаг тийм бүтцүүдтэй байх ёстой юм байна лээ.

Д.Цогтбаатар: Сая Тэмүүжин гишүүний хэлж байгаа бол яг миний нөгөө түрүүний хэлж байгаатай утга давхацлаа гэж би ойлголоо. Өөрөөр хэлбэл тухайлан ийм юм заахгүй. Угаасаа

энэ улсын оршин тогтнож байгаа, энэ хууль хэрэгжүүлж байгаа, манай Хууль зүйн байнгын хороо гол ярьж байгаа юм л хүний эрхийн тухай асуудал шүү дээ. Тэгэхээр яг ийм. Тэгэхдээ нэгэнт ийм бол дэд хороо байгаа. Тэгээд бид нар бол энэ дэд хорооныхоо даргыг энэ сонгох ажил явуулж байна. Гэхдээ саяын таны ярьдаг зүгээр Монголд бол бас ийм л байгаа юм. Би бол Хүний эрхийн дэд хороо байхад буруу зүйл байхгүй. Яагаад гэвэл үүнийг яг шийдэх эрхтэй хүмүүс нь бид нар өөрсдөө энд тэгээд шийдэж байна шүү дээ. Энэ асуудлыг онцгойлон ингэж зааж өгөхгүй бол хүний эрх Монголд сайхан байгаа юу гэвэл бас тэрэн шиг худлаа юм байхгүй шүү дээ. Яг газар дээрээ төрийн албан хаагч дээр очоод л, зүгээр нотариат дээр очиход яаж хүлээж, хүндрүүлж болох вэ гэдгийг зүгээр эндээс гараад л бид нар мэдэрч болно.

Тэгэхээр энэ дээр чинь зүгээр хүний яг амьдралд шуурхай үйлчлээд явах ёстой тэр бүх бичиг захиргааны, жишээлбэл хүсэлт гаргахад тэд хоногийн дотор хариу өгнө гээд тэд хоногтоо өгөхгүй байгаа шүү дээ. Энэ чинь хүний эрх нь зөрчигдөөд яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ биелүүлэлт тал дээр бол онцгой анхаарах үүднээс энэ дэд хороо бол байж байхад би бол буруудахгүй байх гэж бодож байна.

Гишүүд үг хэлээд дууссан болохоор би Эрдэнэболд гишүүнд хандаад бас нэг цөөн хэдэн зүйл хэлчихье гэж бодож байна.

I дүгээрт, ер нь сая энэ Нара гишүүн ч гэсэн үг аваад хэлж байгаа нь цаанаа нэг зүйлийг хэлж байгаа байх. Юу энд бол цөөнх сөрөг хүчин гэж бас байгаа шүү, бид хүний эрхийн асуудал дээр дуугарна шүү гэдэг өнцгөөсөө үгээ хэлж байна гэж би бодож байна. Энэ юуг бол, одоо Их Хурлын бүлгийн удирдлагуудын түвшинд, Их Хурлын удирдлагуудын түвшинд ч гэсэн нэг ярьж байгаа зүйл бол ер нь бол энэ ротацтай байх нь зөв

байх. Ингээд нэг томилогдоод л тэр чигээрээ нэвт яваад дуусах биш, ротацтай ээлжтэй, дугаартай ийм бас байвал зүгээр байх аа гэдэг санаа яригдаж байгаа. Үүнийг тэгэхээр би бас энд онцлоод цохон тэмдэглэмээр байгаа юм.

Эрдэнэболд гишүүний хувьд бол залуу хүн, зоригтой ажиллаарай. Хүний эрхийн төлөө ажиллана гэдэг бол даргын эсрэг ажиллана гэсэн үг шүү. Яагаад гэвэл хүний эрхийг хэн зөрчдөг вэ гэвэл энд, тэнд байгаа дарга нар зөрчдөг. Одоо бид нар энд өчнөөн хүний эрх яриад яг сэтгэлээсээ ингээд хүний эрхтэй холбогдсон юмнуудаа сайжруулах гээд яваад байхад иргэд хүний эрх бас хэцүү байна шүү дээ гээд яриад байгаа нь яагаад гэвэл хаа газар очоод I даргын үүдэн дээр очоод ажил нь бүтэхгүй, өшөө ил, далд юм нэхээд ингээд байгаа учраас л иргэд тэгж яриад байгаа юм.

Тэгэхээр наадах чинь тийм амар ажил биш шүү. Даргад таалагдах гэж ажиллах биш, олон нийт иргэдэд таалагдах гэж, тэд нарын эрхийг хамгаалах гэж, чин сэтгэлээсээ ажиллах ажил шүү. Энэ ардчилсан нийгэмд ямар ч дарга цаг хугацаатай. Харин ард түмэн мөнх. Тэр төр гэдгийг чинь бий болгох гол суурь нь ард түмэн байгаа юм. Тэр ард түмэн хүсэж байж, төр өөрөө бий болж байгаа юм. Тэгэхээр ард түмний хүсэл эрмэлзлийн биелэл нь төр байхгүй юу. Тэгэхээр I дүгээрт, тэр ард түмнийхээ хүсэл эрмэлзлийг харж, төрийг ард иргэдийн эрхийн өмнө байранд нь байлгах тухай асуудал яригдаж байгаа юм. Түүнээс төр нь том болчихсон ард иргэдээ загнаад л, жагсах жагсахгүйг нь хэлж өгөөд байх тухай асуудал огтоос биш шүү.

Тэгэхээр та энэ дээр ирж байгаа чинь дарга цэрэг болж байгаадаа биш. Танд жижиг асуудал гэж байхгүй болсон. Энгийн иргэний амьдралын нэг хүний нэг асуудал чинь энэ улсын том

асуудал гэдгийг та мэдрүүлж
ажиллаарай гэж би хүсмээр байна.

Ингээд үг хэлж дууслаа. Үгүй ээ,
одоо бол байхгүй шүү дээ.

Ингээд санал хураалт явуулъя.
Түрүүн энэ Хүний эрхийн дэд хорооны
даргаар Улсын Их Хурлын гишүүн
Сүхбаатарын Эрдэнэболдыг сонгохыг
дэмжье гэсэн томъёоллоор санал
хураалт явуулъя.

86,7 хувиар санал дэмжигдлээ.

Дэд даргыг сонгох тухай Байнгын
хорооны тогтоолын төслийг та бүхэнд
унишиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын
хорооны тогтоол. 2024 оны 10 дугаар
сарын 22. Дугаар тавигдана.
Улаанбаатар хот. Дэд хорооны даргыг
сонгох тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай
хуулийн 27 дугаар зүйлийн 27.10, 27.11
дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь
хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн
Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ
нь:

Монгол Улсын Их Хурлын Хүний
эрхийн дэд хорооны даргаар Улсын Их
Хурлын гишүүн С.Эрдэнэболдыг
томилсугай.

Хууль зүйн байнгын хорооны дарга
Д.Цогтбаатар.

Ингээд танилцууллаа. Эрдэнэболд
гишүүндээ баяр хүргэе. Амжилт хүсье.

13.23 цаг

Дараагийн асуудалдаа оръё. 3 дахь
асуудал.

**“ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг
сонгон шалгаруулах ажлын хэсэг
байгуулах тухай” Байнгын хорооны
тогтоолын төслийг хэлэлцэж эхэлбэ.**

Хууль зүйн байнгын хороо Монгол
Улсын шүүхийн тухай хуулийн 77.2-т
заасан байгууллагуудад, ажлын хэсэгт
нэр авах тухай албан тоотыг хүргүүлж,
2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор
ирүүлсэн нэрсийг үндэслэн ШЕЗ-ийн
шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах
ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын
төслийг бэлтгэн та бүхэнд тараасан
байгаа.

Байнгын хорооны тогтоолын
төсөлтэй холбогдуулан асуулт асуух
гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ингээд асуулт асуух гишүүд
байхгүй байна.

Байнгын хорооны төсөлтэй
холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө
үү? Алга байна.

Үгүй ээ, та тэгээд боломж өгч
байхад чинь яагаагүй байж. Би түрүүн
өгсөн шүү дээ, тийм.

Ингээд санал хураалт явуулж
эхэлбэ.

Монгол Улсын Их Хурлын даргаас
томилсон Улсын Их Хурлын гишүүн
Цэндийн Сандаг-Очирын ажлын хэсгийн
бүрэлдэхүүнд оруулж ажлын хэсгийн
ахлагчаар томилохыг дэмжье гэсэн
санал хураалт явуулъя.

86,7 хувиар санал дэмжигдлээ.

2. Улсын Их Хурал дахь олонхын
бүлгээс санал болгосон. Улсын Их Хурал
дахь олонхын бүлгээс санал болгосон
Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн
ажлын албаны дэд дарга О.Бат-
Эрдэнийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд
оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор
санал хураалт явуулъя.

80 хувиар санал дэмжигдлээ.

3. Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс санал болгосон Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн Хүний эрх, эрх зүйн бодлогын зөвлөх Х.Номингэрэлийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

80 хувиар санал дэмжигдлээ.

4. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санал болгосон Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболдыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

73,3 хувиар санал дэмжигдлээ.

5. Монгол Улсын Засгийн газраас санал болгосон ЗГХЭГ-ын дэд дарга Б.Батцэцэгийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

6. Яах вэ, батлагдчихаж байгаа юм чинь юу, Эрдэнэболд гишүүн дэмжсэн санал өгсөн байна. Протоколд дэмжсэн гэснээр тэмдэглэж авч үлдье.

6. ХЭҮК-оос санал болгосон ХЭҮК-ын гишүүн Дондовыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

73,3 хувиар санал дэмжигдлээ.

7. Монголын хуульчдын холбооноос санал болгосон Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн Ц.Мөнхбатыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

8. Монголын Өмгөөлөгчдийн холбооноос санал болгосон Монголын

Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн З.Сүхбаатарыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

9. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс санал болгосон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

10. МУИС-ийн Хууль зүйн сургуулиас санал болгосон МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал Б.Амарсанааг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

11. Төрийн бус өмчийн Хууль зүйн сургуулиас санал болгосон Отгонтэнгэр их сургуулийн ахлах багш С.Эрдэнэболорыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд ажлын хэсэг 11 хүний бүрэлдэхүүнтэй хүн тус бүрээр санал хурааж дууслаа.

“ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

73,3 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. 2024 оны ... дугаар сарын ... дугаар өдөр. Дугаар. Улаанбаатар хот.

ШЕЗ-өөс шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1.6, 77.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ШЕЗ-ийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 6.1, 6.2, 6.3 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн гишүүд О.Бат-Эрдэнэ Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн ажлын албаны дэд дарга, Х.Номингэрэл Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн Хүний эрх, эрх зүйн бодлогын зөвлөх, Ж.Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга, Б.Батцэцэг ЗГХЭГ-ын дэд дарга, С.Дондов Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Ц.Мөнхбат Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн, З.Сүхбаатар Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Б.Амарсанаа МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, С.Эрдэнэболор Отгонтэнгэр Их сургуулийн ахлах багш. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Галсанбат Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны ахлах мэргэжилтэн.

2. ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, нэр дэвшигчийг Хууль зүйн байнгын хороонд танилцуулахыг Ажлын хэсэг Ц.Сандаг-Очирт даалгасугай.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар.

Ингээд танилцуулж дууслаа.

Тогтоолыг баталлаа.

Ингээд байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаандаа оролцсон гишүүдэд талархал илэрхийлж байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ